



# ОХИДЫН ЭРХИЙН ЗӨРЧИЛ: “ОХИДЫН ҮЗЛЭГ”-ТЭЙ ХОЛБОГДОХ АСУУДАЛ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН


УЛААНБААТАР ХОТ  
2021 он

Судалгааны багийн ахлагч: Ж.Содномдаржаа /Судлаач/

Судалгааны багийн гишүүн: Х.Эгшиглэн /Судлаач/

Судалгааны багийн гишүүн: Л.Лхагвасүрэн /MSW/



 976-70159688

## ГАРЧИГ

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>5</b>
<b>ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ</b>	<b>6</b>
<b>УДИРТГАЛ</b>	<b>7</b>
<b>НЭГ. “ОХИДЫН ҮЗЛЭГ” ХҮҮХДИЙН ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙГАА ЭСЭХ</b>	<b>8</b>
<b>1.1 Халдашгүй, чөлөөтэй байх эрх ба түүний агуулга</b>	<b>8</b>
a) Охидын халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах	8
<b>1.2 Охидын эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх ба “охидын үзлэг”</b>	<b>9</b>
a) Сайн дурын буюу зөвшөөрлийн үндсэн дээр “охидын үзлэг”-т хамрагдах	9
b) Урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга “охидын үзлэг” мөн үү	12
c) Охидыг шаардлагагүй үзлэгт оруулснаас үүсэх сөрөг үр дагаврууд	14
<b>1.3 “Охидын үзлэг”-ийг зохион байгуулж буй эрсдэлтэй орчин</b>	<b>15</b>
a) Сургуулийн орчинд хийгдэж буй “охидын үзлэг”-ийн асуудал	16
b) Бусад эрсдэлтэй орчин	18
<b>1.4 ЭМС-ын тушаалуудын хууль зүйн хүчин чадал</b>	<b>19</b>
<b>1.5 Бүлгийн дүгнэлт</b>	<b>20</b>
<b>ХОЁР. ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ХАМГААЛАЛТ БА “ОХИДЫН ҮЗЛЭГ”</b>	<b>22</b>
<b>2.1 Хувь хүний нууцын хамгаалалт</b>	<b>22</b>
a) Хувь хүний нууцыг ил болгох үндэслэл	22
b) Бусад хууль тогтоомжийн зохицуулалт	23
c) Хувь хүний нууцыг хамгаалах процессыг тодорхой тусгах	23
<b>2.2 Хувь хүний нууц задарснаас үүсэх сөрөг үр дагавар</b>	<b>26</b>
<b>2.3 Хувь хүний нууц задалсан этгээдэд хүлээлгэх хариуцлага</b>	<b>27</b>
<b>2.4 Бүлгийн дүгнэлт</b>	<b>28</b>
<b>ГУРАВ. ОХИДЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ</b>	<b>29</b>
<b>3.1 Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй бодлого, үйлчилгээ</b>	<b>29</b>
a) Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын бодлого	29
b) Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ	30
<b>3.2 Захиргааны журмаар охидын эрхийг хамгаалах</b>	<b>30</b>
a) Хүний Эрхийн Үндэсний Комисс	30
b) Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (Хүүхдийн эрхийн тухай хуулиар эрх олгосон)	31
<b>3.3 Нийтийн эрх ашгийг хамгаалах шүүхийн нэхэмжлэл (Захиргааны хэргийн шүүх)</b>	<b>31</b>
<b>3.4 Бүлгийн дүгнэлт</b>	<b>32</b>

<b>ДӨРӨВ. БОДЛОГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>33</b>
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	<b>35</b>
ХАВСРАЛТ-1. ЭМСайд С.Энхболдод хүргүүлсэн албан бичиг	<b>37</b>
ХАВСРАЛТ-2. ХЭҮК-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунанд хүргүүлсэн албан бичиг	<b>39</b>
ХАВСРАЛТ-3. БШУСайд Л.Энх-Амгаланд хүргүүлсэн албан бичиг	<b>40</b>
ХАВСРАЛТ-4. БШУЯ-наас ирүүлсэн хариу албан бичиг	<b>41</b>
ХАВСРАЛТ-5. ХЭҮК-оос ирүүлсэн хариу албан бичиг	<b>42</b>
ХАВСРАЛТ-6. Дархан-Уул аймгийн “Амин Холбоо” Өрхийн эрүүл мэндийн төвийн “Од” цогцолбор сургуулийн захиргаанд хүргүүлж байсан албан бичиг	<b>43</b>

## ӨМНӨХ ҮГ

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоохын төлөө НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ буюу ONE BILLION RISING олон улсын хөдөлгөөнийг 2013 оноос эхлэн жил бүр Монголын эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр “Хөөрхөн Зүрх” ТББ болон хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагууд нэгдэн зохион байгуулж урлагаар дамжуулан дуу хоолойгоо илэрхийлдэг билээ.

2019 оноос эхлэн “Хөөрхөн Зүрх” ТББ болон Охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” Төв нь “Сургуулийн орчин дахь охидын үзлэг”-ийн асуудлаар охид, эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран шат дараатай үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсээр 2021 онд НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ буюу ONE BILLION RISING олон улсын хөдөлгөөнөөр дамжуулан хүний эрхэд суурилсан хандлагыг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн зөрчлийг таньж мэдэх улмаар жендэрт суурилсан хүчирхийллийг таслан зогсоох, тэр дундаа жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг бий болгож, охид, эмэгтэйчүүдийн бэлгийн эрх, эрх чөлөө халдашгүй дархан байдлын эсрэг хүний эрхийн ноцтой зөрчил болох «Сургуулийн орчин дахь охидын үзлэг»-ийн таслан зогсооход чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгууллаа.

Уламжлалт нэршлээр “Охидын үзлэг” буюу бэлгийн харьцаанд орсон, эсвэл бэлгийн замын халдварт өвчинтэй эсэхийг шалгах үзлэг нь охид, эмэгтэйчүүдийн хүний эрхийн ноцтой зөрчил, ялгаварлан гадуурхалт бөгөөд шинжлэх ухаанч бус, бэлгийн харилцаанд орсон эсэхийг бүрэн тодорхойлох боломжгүй, эмнэлгийн ач холбогдолгүй, урт хугацааны эрүүл мэндийн болон сэтгэлзүйн сөрөг үр дагавартай хэмээн дэлхий нийтээр; Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар, Эмэгтэйчүүдийн байгууллага, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага зэрэг газруудаас эрс буруушаадаг, хүний эрхийн талбарт ухралт хийж буй арга зүй хэмээн үзэж, таслан зогсоох чиглэлээр зөвлөмжүүдийг гаргасан байдаг. Монгол Улсын нэгдэн орсон, соёрхон баталсан НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Хүүхдийн эрхийн конвенцод тусгаж хамгаалсан охид, эмэгтэйчүүд халдашгүй дархан байх эрх, бие махбодын хувьд халдашгүй байх эрх, эрүүл мэндийн дээд зэргийн чанартай үйлчилгээ авах эрх, амьд байх эрх цаашилбал эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах, хэрцгийлэл доромжлолоос ангид байх, өөрийнх нь чөлөөтэй өгсөн зөвшөөрөлгүйгээр хэнийг ч эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилтад оруулахгүй байх эрх зэрэг эрхүүдийг ноцтойгоор зөрчиж буй хэлбэр юм.

Бид үндэсний хэмжээнд (21 аймаг, 9 дүүрэг) 500 гаруй мэргэжилтнүүдийг хамарсан “Сургууль ба охидын үзлэг” хэлэлцүүлгийг зохион байгуулж хэлэлцүүлгийн үр дүн, санал, зөвлөмж болон хууль эрх зүйн баримт бичиг, бодит кейс дээр дүгнэлт, шинжилгээ хийж “Охидын эрхийн зөрчил: Охидын үзлэгтэй холбогдох асуудал” баримт бичгийн судалгааг хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгааны тайлан нь цаашид “Сургуулийн орчин дахь охидын үзлэг”-ийг таслан зогсоож, өсвөр үеийнхэн, охид эмэгтэйчүүдэд хүний эрхэд суурилсан хандлагаар эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд бодлогот өөрчлөлт оруулахад том хувь нэмэр болно гэдэгт найдаж байна.

## ХУРААНГУЙЛСАН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЕБС	Ерөнхий болосролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГтХ	Засгийн газрын тухай хууль
ЗЕХ	Захиргааны Ерөнхий хууль
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ЗХДтХ	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль
ШШтХ	Шүүх шинжилгээний тухай хууль
НУБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд гэж хойно нь оруулах
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирүс
ХЗДХЯ	Хууль Зүй Дотоор Хэргийн Яам
ХХНтХ	Хувь хүний нууцын тухай хууль
ХХтХ	Хүүхэд хамгааллын тухай хууль
ХЭтХ	Хүүхдийн эрхийн тухай хууль
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭМС	Эрүүл Мэндийн Сайд
ЭХШХШтХ	Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЭМтХ	Эрүүл мэндийн тухай хууль

## УДИРТГАЛ

Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхээр Үндсэн хуулиа баталж, хүний эрх, эрх чөлөөг тунхаглан, төрөөс хүний эрхийг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хэрвээ зөрчигдсөн нөхцөлд таслан зогсоох, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хамгаалах үүргийг хүлээсэн.

Үндсэн хуулиар хамгаалсан хүний үндсэн эрхийн тулгуур “халдашгүй чөлөөтэй байх” эрхийг тусгаж аливаа хүн өөрийнхөө амьдралаар амьдрах, өөрт холбогдох асуудлыг өөрөө шийдвэрлэх, бусдаас бие даасан, хараат бус, чөлөөтэй амьдрахыг энгийнээр ойлгодог.

Хэдийгээр “охидын үзлэг” нь нэг талаасаа эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хүртээмжтэй, чанартай болгох эрхийг хангахад чиглэсэн боловч, нөгөө талдаа халдашгүй, чөлөөтэй байх үндсэн эрхэд халдаж байж болзошгүй нөхцөл байдлууд “Охидын дуу хоолой” социологийн судалгаа, 2019 онд Дархан-Уул аймагт гарсан тохиолдол зэргээр илэрдэг. Тухайлбал, Аливаа эрүүл мэндийн үзлэг тухайн хүний зөвшөөрөл, сайн дурын үндсэн дээр хийгдэх ёстой ч “Охидын үзлэг” зөвшөөрөлгүй, хүчээр хийгддэг, татгалзах аргагүй байдаг гэдгийг судалгаанд хамрагдсан охидын дийлэнх нь хэлсэн байна.

Гэтэл боловсролын салбарын бодлогыг тодорхойлох чиг үүрэг бүхий БШУЯ-наас 2015 оноос сургуулийн орчинд “Охидын үзлэг” хийгдээгүй гэсэн байр суурийг хүчтэй баримталдаг.

ЭМС-ын 2017 оны А/399 дугаар тушаал, 2020 оны А/364 дүгээр тушаалуудын хавсралтаар батлагдсан журмуудад “охидын үзлэг” хийхдээ зөвшөөрлийн үндсэн дээр, эмнэлгийн орчинд хийнэ гэдгийг тодорхой тусгаж өгсөн ч хэрэгжилт дээр анхаарах зайлшгүй шаардлагатай байна. Мөн ЭМС-ын 2017 оны А/399 дүгээр тушаал, 2020 оны А/364 дүгээр тушаалуудын хууль зүйн үндэслэл буюу хуулиар тусгайлан эрх олгосон уу, мөн ЗЕХ-д заасан шаардлага, нөхцөлийг хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Охидын үзлэг орсон, үзлэгийн үр дүн зэрэг нь хувийн нууцад хамаарах мэдээлэл бөгөөд хувийн нууцыг хадгалах, хамгаалах, задрахаас урьдчилан сэргийлэх асуудал Хувь хүний нууцын тухай хуулиар, ЭМС-ын тушаал, журмуудаар ч хангалттай хэмжээнд тусгагдаж, хангагдаж чадаагүй. Үүнээс үүдэж дараа дараагийн сөрөг үр дагаврууд үүсэж байж болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлыг үүсгэж байна. Хүүхдийн хувийн нууц мэдээлэл задарсан нөхцөлд сургуулийн орчинд суралцах боломжгүй болж сургууль завсардалт, шилжих, ялгаварлан гадуурхалтад өртөх, амиа хорлох хүртэл хор уршиг учирч болзошгүй юм.

Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ өмнө энэ чиглэлээр хийгдсэн судалгааны материалууд дээр хоёрдогч анализ хийх, “Сургууль эмнэлэг биш” кампанит ажил болон НЭГ ТЭРБУМААРАА ТЭМЦЬЕ буюу ONE BILLION RISING 2021 олон улсын хөдөлгөөний хүрээнд болсон хэлэлцүүлгүүдийн тэмдэглэл, “Хөөрхөн зүрх” ТББ-д сургуулийн орчинд “Охидын үзлэг” хийх гэж байгаагаа мэдээлсэн тохиолдлууд, БШУЯ, ЭМЯ, ХЭҮК-т тодруулга авах байдлаар албан бичиг хүргүүлж, хариу ирүүлсэн байр суурь зэрэг анхдагч эх сурвалжийг ашиглан боловсруулав.

“Охидын дуу хоолой” социологийн судалгааг суурь болгон ашигласан бөгөөд тухайн харилцааг судлан суурь мэдээллийг боловсруулсан нь энэхүү судалгааг хийхэд илүү дөхөм, хийх боломжтой болгосон гэдгийг дурдмаар байна.

## Нэг. “ОХИДЫН ҮЗЛЭГ” ХҮҮХДИЙН ХАЛДАШГҮЙ, ЧӨЛӨӨТЭЙ БАЙХ ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙГАА ЭСЭХ

### 1.1 Халдашгүй, чөлөөтэй байх эрх ба түүний агуулга

Хүн бүр халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй<sup>1</sup> буюу хувийн орон зай, хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцохгүй байх, хувийн, гэр бүл, захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг хуулиар хамгаалах<sup>2</sup> үүргийг төр хүлээдэг. Үүнээс хүүхдийн эрхийг тусгайлан авч үзэж хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэхээр<sup>3</sup> Үндсэн хууль, олон улсын конвенцуудад<sup>4</sup> тусгагдсан.

Хүүхдийн халдашгүй, чөлөөтэй байх эрх нь бие махбод, хувийн халдашгүй байдал, гэр бүлийн харилцааны халдашгүй байдал, нэр төр, алдар хүнд халдашгүй байх... зэрэг эрхүүдээс<sup>5</sup> бүрдэж байна.

Хүүхдийн нас, төлөвшилтийн байдлыг харгалзан өөртэй нь хамаарал бүхий шийдвэр гаргахдаа харгалзан үзэж байх<sup>6</sup>, өөрийн амьдралыг төлөвлөх, эцэг, эх, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн өөрийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэрүүдийг гаргах, хувийн нууцтай байх, хувийн нууцаа хамгаалуулах, өөрөө хамгаалах<sup>7</sup> зэрэг өргөн хүрээтэй байна.

#### а) Охидын халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалах

Төрөөс хүүхдийн халдашгүй чөлөөтэй байхыг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хэрвээ зөрчигдсөн нөхцөлд тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцахаар<sup>8</sup> тунхагласан.

Хүүхдийн эрхийг хамгаалах хүрээнд хууль зүйн орчинг бүрдүүлж, түүнийгээ сайжруулах хүрээнд анхаарч ирсэн бөгөөд 2016 онд хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх харилцааг зохицуулахаар Хүүхдийн эрхийн тухай хуулийг баталсан. Хүүхэд өөрийн орон зайг хамгаалуулах<sup>9</sup> эрхтэй, мөн хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох<sup>10</sup> эрхтэй гэдгийг баталгаажуулсан.

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13

<sup>2</sup> Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 12-р зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн 16.

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11

<sup>4</sup> Хүүхдийн эрхийн тухай конвенц 16.2

<sup>5</sup> О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” Хүний эрх сэтгүүл, 2016/01, 21 дэх тал.

<sup>6</sup> Хүүхдийн эрхийн тухай конвенц 12.1

<sup>7</sup> О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” Хүний эрх сэтгүүл, 2016/01, 14 дэх тал.

<sup>8</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1

<sup>9</sup> Хүүхдийн эрхийн тухай хууль 7.3

<sup>10</sup> Хүүхдийн эрхийн тухай хууль 8.1.2



Мөн хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй харилцааг зохицуулахаар Хүүхэд хамгааллын тухай хуулийг баталсан. Гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, цахим орчин, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээн дэх хүүхэд хамгааллын асуудлыг тусгайлан зохицуулж өгсөн. Сургалтын байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гарган мөрдөх үүрэгтэй<sup>11</sup> байх бөгөөд сургуулийн орчинд хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх<sup>12</sup> үүргийг хүлээдэг.

## 1.2 Охидын эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх ба “охидын үзлэг”

Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах үндсэн эрхтэй.<sup>13</sup> Хүүхэд, залуучуудын эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй байлгах хүрээнд анхаарч өсвөр үеийн кабинетыг байгуулж<sup>14</sup>, эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх болсон байна. Өсвөр үе, залуучуудын кабинет нь хорт, зуршил, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл дадал, хэвшилтэй болгож төлөвшүүлэх<sup>15</sup>, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор байгуулагдаж, ЭМС-ын 2017 оны А/399 дүгээр тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц”-д заасан үйлчилгээг үзүүлдэг.

ЭМС-аас 2020 онд “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх<sup>16</sup> хүрээнд А/364 дүгээр тушаалын хавсралтаар “Охидын эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг баталсан.

ЭМС-ын 2017 оны А/399 болон 2020 оны А/364 дугаар тушаалуудын хавсралтаар батлагдсан журамд “оходод үзлэг” хийхтэй холбоотой зааварчилгаа тусгагдсан.

Эдгээр журмуудад “охидын үзлэг”-ийг эмнэлгийн зориулалтын орчинд буюу бүх шатны эрүүл мэндийн байгууллага<sup>17</sup>, өсвөр үе залуучуудын кабинетад<sup>18</sup> хийж байхаар зохицуулж өгсөн.

### а) Сайн дурын буюу зөвшөөрлийн үндсэн дээр “охидын үзлэг”-г хамрагдах

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ шаардлагатай болсон нөхцөлд хүүхэд өөрийн сайн дурын үндсэн дээр (хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл) охид эмнэлгийн тусламж үйлчилгээ өсвөр үеийн кабинет, бүх шатны эмнэлгийн байгууллагуудаар дамжуулан авах боломжтой.

<sup>11</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.1

<sup>12</sup> Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.3.4

<sup>13</sup> Үндсэн хуулийн 16.6

<sup>14</sup> Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны А/399 дугаар тушаалын хавсралт 1-р “Өсвөр үеийн кабинетын үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан.

<sup>15</sup> Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн 10.1

<sup>16</sup> Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 3.2.3.1

<sup>17</sup> ЭМС-ын 2017 оны А/399 дугаар “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” тушаалын 3 дахь заалт, Өсвөр үеийн кабинетын үлгэрчилсэн дүрмийн 2.5

<sup>18</sup> ЭМС-ын А/364 дүгээр тушаалын 2 дахь заалт

Охидыг албадан, тухайн хүүхдийг хүсээгүй байгаа үед нь эрүүл мэндийн үзлэгт оруулах зохицуулалт байдаггүй. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд зөвхөн онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлах<sup>19</sup> ёстой.

Эрүүгийн гэмт хэргийн хохирогч болсон нөхцөл ЭХШХШТХ-ийн 27.1 дэх хэсгийн 2.2-т хүний эрүүл мэндэд учирсан хохирлын шинж байдлыг тогтоох гэсэн үндэслэлээр биед үзлэг хийх болно, ШШТХ-ийн 28.3-т заасны дагуу шүүх тогтоол, шүүгч захирамж гаргаж, 29.6-т Шинжилгээ хийлгэх этгээд нь 16 насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бол түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг авсны үндсэн дээр үзлэг хийхээр заасан.

**Тохиолдол 1.**

Ө аймагт дөнгөж төрсөн нярайг хаясан тохиолдол гарсантай холбогдуулан тус аймгийн Цагдаагийн хэлтсээс хүүхдийн төрсөн эхийг эрэн сурвалжлах үйл ажиллагааг яаравчлуулах зорилгоор охидын гэнэтийн үзлэгийг зохион байгуулсан. Хэдийгээр охидын бэлгэ эрхтнийг үзлэгт оруулаагүй ч биеийн хувийн хэсэг болох “хөх”- ний хэсгийг охидын зөвшөөрөлгүйгээр тэмтрэх үзлэгийг зохион байгуулсан.

*Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он*

Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх хүрээнд халдвар илрүүлэх шинжилгээнд сайн дурын үндсэн дээр<sup>20</sup>, ямар нэгэн байдлаар албадан хамруулахгүй<sup>21</sup> байхаар тусгасан байдаг.

ЭМС-ын 2017 оны А/399 дугаар тушаалаар батлагдсан “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц”-ын 2.2-т тусгай үзлэг хийхийн өмнө бэлгийн бойжилт хэрхэн явагдаж байгааг үнэлэх зорилгоор үзлэг хийх гэж байгаагаа хэлж, зөвшөөрөл авна. Үзлэг, ажилбарыг тодорхой тайлбарлан тусгайлсан үзлэг хийнэ. Үйлчлүүлэгч зөвшөөрөөгүй тохиолдолд тусгайлсан үзлэг хийхгүй, 6-т бэлгийн замаар дамжих халдварууд (БЗДХ) 4.2. Үзлэг хийх. Үзлэг хийхдээ эелдэг харьцах, үйлчлүүлэгч өөрөө хүсээгүй байхад үзлэг хийхгүй, анхны үзлэг болон цаашид хийгдэх үзлэг бүрийн тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивд хадгална гэж тусгасан.

ЭМС-ын 2020 онд А/364 дүгээр тушаалын дагуу батлагдсан “Охидын эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар”-ын 1.6-д үзлэг хийхдээ бага насны охидын хувьд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр, өсвөр насны охидын хувьд өөрсдийнх нь зөвшөөрснөөр сайн дурын үндсэн дээр хийнэ. Үзлэгийн өмнө үзлэг хэрхэн хийх, биеийн ерөнхий үзлэг, хөхний болон нөхөн үржихүйн эрхтний тусгайлсан үзлэг хийхийн ач холбогдол зэргийг тайлбарлана гэж тусгасан байна.

Иргэний хуульд заасны дагуу өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно<sup>22</sup> гэж тусгасан, шаардлагатай

<sup>19</sup> Үндсэн хуулийн 19.2

<sup>20</sup> Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 10.1.2.ажилтныг хүний дархлал хомсдолын вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд сайн дураар хамрагдахыг дэмжих;

<sup>21</sup> Хүний дархлал хомсдолын вирусийн халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 10.1.3.ажилтныг энэ хуулийн 10.1.2-т заасан шинжилгээнд албадан хамруулахгүй байх;

<sup>22</sup> Иргэний хуулийн 15.1

нөхцөлд 16-18 нас хүртэлх насны иргэний өөрийнх нь хүсэлт, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж шүүхээс тооцож болохоор<sup>23</sup> тусгасан байдаг. 7-14 хүртэлх насны хүүхэд иргэний эрх зүйн зарим чадамжтай<sup>24</sup> буюу хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусдыг хууль ёсны төлөөлөгч нь төлөөлж хийдэг бол, 14-18 хүртэлх насны хүүхэд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай буюу хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийдэг<sup>25</sup> “өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах”, “өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх”, “өөрийн үзэмжээр захиран зарцуулж болох орлогыг банк, зээлийн байгууллагад хадгалуулах” зэргийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр бие даан хэрэгжүүлж болохоор тусгасан.

Өсвөр үе гэж ЭМС-ын 2017 онд баталсан журамд 10-19 насны хүнийг ойлгохоор тусгасан, 2020 онд баталсан журамд 8-19 насны хүнийг бэлгийн бойжилтын үе гэж тус тус авч үзэж ангилсан. Иргэний хуульд заасны дагуу 14 хүртэлх насны хүүхдийг “охидын үзлэг”-т хамруулах нөхцөлд зайлшгүй хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр хамруулах ёстой. Харин 14-18 насны хүүхдийн хувьд өөрийн зөвшөөрлөөр хамрагдах нь зөв үү? гэдэг нь хууль зүйн хувьд эргэлзээтэй. Иргэний хуулиар эрх зүйн чадамжийн талаар зохицуулсан бөгөөд өөртөө хохиролгүй үйлдэл мөн үү? Хэрвээ үзлэгээс шалтгаалж сөрөг үр дагаврууд үүсвэл энэ нь өөртөө хохиролгүй үйлдэлд хамаарах уу? зэрэг эргэлзээтэй асуултууд байгаа. Нөгөө талаасаа хүүхэд үзлэгт орсон талаар, үзлэгийн үр дүнг эцэг, эхдээ мэдэгдэх хүсэл, сонирхолгүй байвал яах вэ? зэргийг судалж, нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

ХЭҮК-ын 2019.06.04-ны 1/30 дугаар зөвлөмжид “...Өсвөр насныхны үзлэг оношилгооны нууцлал, мэдээллийг чандлан хадгалах, баталгаа зохицуулалтыг журамлах; Ингэхдээ өсвөр насныхны эрүүл мэндийн үзлэгийн үр дүнг шаардлагатай бол тодорхой хугацаанд эцэг эхэд мэдэгдэхгүй тэр дундаа багшид мэдэгдэхгүй байхаар зохицуулах...” гэж тусгаж өгсөн байдаг. ЭМЯ-наас журам гаргахдаа эрх зүйн талаас нарийн анализ хийж тусгах шаардлагатай гэдэг нь харагдаж байна.

Гэвч бодит байдал дээр 2020 онд хийгдсэн “Охидын дуу хоолой” судалгаанд<sup>26</sup> хамрагдсан охидын 72.2% нь үзлэгт оруулахдаа огт зөвшөөрөл аваагүй гэж хариулсан бол, 46.4% гэнэт үзлэгт оруулсан буюу үзлэгт оруулах талаар урьдчилж ямар нэгэн мэдээлэл өгөөгүй гэж хариулсан. Хэрвээ чи үзлэгт орохоос татгалзвал яах вэ? гэсэн асуултад 48% нь миний татгалзах татгалзахгүй хамаагүй үзлэгт хүчээр оруулна, 27% нь үзлэгт оруулахгүй ч үзлэгт ороогүйг бусад хүүхдүүд мэдээд намайг муугаар хэлнэ, 13% нь үзлэгт оруулахгүй, 12% нь үзлэгт оруулахгүй ч багш буруугаар ойлгож надад таагүй хандана гэсэн хариултыг өгсөн байна. Дээрх социологийн судалгааны үр дүн ЭМС-ын тушаалууд нь охидоос зөвшөөрөл авах зохицуулалт хангалттай хэмжээнд хэрэгжиж чадахгүй, хүүхдүүдэд татгалзах эрхтэй гэдгийг тайлбарлаж өгдөггүй, зөвшөөрөл авдаггүй, урьдчилж мэдэгддэггүй “Охидын үзлэг”-т оруулдаг тохиолдол байгаа гэдгийг харуулж байна.

<sup>23</sup> Иргэний хуулийн 15.2

<sup>24</sup> Иргэний хуулийн 17.1

<sup>25</sup> Иргэний хуулийн 16.1

<sup>26</sup> Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр, Гүнж төв, “Охидын дуу хоолой” Ерөнхий Боловсруулсан Сургуулиуд дээр хийгддэг охидын үзлэгийн талаарх судалгааны тайлан, УБ, 2020 он

**Тохиолдол 2.**

Д аймгийн ..... сумын сургуульд охид, хөвгүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулдаг. Урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад тус сургуулийн мэргэжилтэн хүүхдээс “зөвшөөрөл”-ийн хуудсыг өгч, зөвшөөрөл авч хийдэггүй тухай мэдээлэв.

*Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он*

**в) Урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга “Охидын үзлэг” мөн үү?**

ЭМС-ын 2017, 2020 оны журмуудад тусгасан зохицуулалтаас үзэхэд дараах зорилгуудыг агуулж байна. Үүнд:

- Бэлгийн бойжилтыг хэрхэн явагдаж байгааг үнэлэх<sup>27</sup>
- Жирэмсэн эсэхийг тогтоох<sup>28</sup>
- БЗДХ өвчтэй эсэхийг тогтоох, илрүүлэх зорилготойгоор хийхээр тусгасан байна.
- 2020 оны ЭМС-ын тушаалаар бүх насны охидод үзүүлэх үйлчилгээг тусгасан. Бага насны охидод журамд заасан шалтгаан байсан нөхцөлд<sup>29</sup> ерөнхий болон тусгай үзлэгийг хийхээр зохицуулсан.

Монголын эмэгтэйчүүдийн сангийн санхүүжилтээр “Хөөрхөн зүрх” ТББ, “ГҮНЖ” төв хамтран Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын үндэсний төвийн дэмжлэгтэйгээр 21 аймаг, 9 дүүргийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтэн, ЕБС-ийн нийгмийн ажилтан, эмч, эрүүл мэндийн багш, цагдаагийн газрын албан хаагчид, аймгийн хүний эрхийн комиссын мэргэжилтэн нарын нийт 500 гаруй анхан шатны нэгж дээр ажиллаж буй төрийн албан хаагчид, мэргэжилтнүүдийг хамруулсан “Сургууль ба Охидын үзлэг” хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт “охидын үзлэг”-ийг ямар шалтгааны улмаас ихэвчлэн зохион байгуулж байгаа талаар “БЗДХ өвчнийг илрүүлэх”, “эрт жирэмслэлтийг илрүүлэх”, “хүчирхийллийн гэмт хэргийг илрүүлэх” гэж дурдсан байдаг.

**Тохиолдол 3.**

... аймгийн цагдаагийн байгууллагаас орон нутгийн өсвөр насны хүүхдүүдийн үзлэгийг зохион байгуулж бэлгийн харилцаанд орсон болон ороогүй тоо мэдээллийг өгөхийг хүсдэг, нэгэн аймагт хохирогч хүүхдийн нэрийг бичээд хүчирхийлэлд өртсөн байна, тэгэхээр танай нутаг дэвсгэр дээр байгаа бүх охидыг “охидын үзлэг”-т хамруулах, судалгаа гаргах шаардлага бүхий албан бичиг ирүүлж байсан.

*Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он*

“Сургууль ба охидын үзлэг” үндэсний хэмжээний хэлэлцүүлэгт оролцогч салбар бүрийн төлөөллийн санал, зөвлөмжид “...цагдаа, прокурорын байгууллагын зүгээс хүүхдийн эсрэг

<sup>27</sup> Журмын 2.2

<sup>28</sup> Журмын 3.3

<sup>29</sup> Журмын 1.6.4.1

үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн мэдээллийг цуглуулах, илрүүлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтан болон өсвөр үеийн кабинетын эмч нараас **“Урьдчилан сэргийлэх” үзлэгийн үр дүн, мэдээллийг албан бичгээр шаардах үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх...**” талаар тусгаж өгсөн.

УИХ-аас 2019 оны 62 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолд:

- 2/Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар:
- 3/Хүүхдийн бэлгийн эрүүл мэнд, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг ерөнхий боловсролын сургуулийн түвшинд үр дүнтэй зохион байгуулах арга замыг тодорхойлж, хүүхдийн нууцыг чанд хадгалдаг, итгэлийг нь хүлээдэг тогтолцоог сургуульд бүрдүүлэхээр тусгасан.

ЭМС-ын 2019.07.04-ний өдрийн 12 дугаар “Хүүхдийн эрүүл мэнд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгаврыг<sup>30</sup> бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн байдаг.<sup>31</sup> Үүнд:

- 1.5. Охид, хөвгүүдийн эрхийг хүндэтгэсэн, албан ёсны зөвшөөрөл авсны үндсэн дээр үйлчилгээ үзүүлэгчдийн санаачилгаар урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх, нууцлал, мэдээллийг хадгалах,
- 1.6. Охидын төрөлт, жирэмслэлт, үр хөндөлт болон эрт гэрлэж байгаа асуудлын шалтгаан, нөхцөлийг судалж, бэлгийн замаар дамжих халдвар, сүрьеэг эрт илрүүлж эмчлэх, бүртгэл хяналт тандалтыг сайжруулах эмч нарын баг гарган ажиллах...-ыг даалгасан байдаг.

Гэтэл урьдчилсан сэргийлэх үзлэг нь БЗДХ (ХДХВ) өвчин, эрт жирэмслэлт, хууль бус үр хөндөлт, бэлгийн хүчирхийллээс үр дүнтэй урьдчилан сэргийлдэг гэж үзэхэд хүндрэлтэй. Урьдчилан сэргийлэх үзлэгийг эрсдэлт бүлэг буюу шаардлагатай хүүхдүүдэд хүргэх талд тодорхой бодлого, зохицуулалт байхгүй. Ингэснээр бүх охидыг үзлэгт хамруулж байгаа нь зорилготойгоо зөрчилдөж, мөн үзлэгт орохыг хүсэхгүй байгаа хүүхдүүдийг хамруулах нь хүүхдийн эрхийн зөрчил үүсгэхэд хүргэж байна.

Охидын үзлэгийг сэргээж нийтээр зохион байгуулах нь үр дүнтэй талаар хэд хэдэн нийтлэлд<sup>32</sup> охид эрт бэлгийн харьцаанд орж байна, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл ихэссэн, бэлгийн харилцаанд эрт орсноор үргүйдэх эрсдэлтэй зэрэг шалтгаанаар “охидын үзлэг” хийх шаардлагатай гэж үзсэн байна. Гэвч “охидын үзлэг” энэ бүхний шийдэл мөн үү гэдэг үндсэн асуултад огт хариулаагүй.

<sup>30</sup> ХЭҮК-оос 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 01/30 дугаар ЭМС-д хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан.

<sup>31</sup> <http://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2018/05/2019-A12.pdf> 2021.04.05-ны өдөр хандав.

<sup>32</sup> Б.Оюунбилэг “Охидын үзлэгийг сэргээе” [www.uniuudur.mn](http://www.uniuudur.mn) вэб сайт, 2019.03.06-ны өдөр нийтлэгдсэн, <https://uniuudur.mn/%D0%BE%D1%85%D0%B8%D0%B4%D1%8B%D0%BD%D2%AF%D0%B7%D0%BB%D1%8D%D0%B3%D0%B8%D0%B9%D0%B3%D1%81%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D1%8D%D0%B52/> 2021.04.17-ны өдөр хандав.

Өсвөр насны хүүхдүүдэд хэзээ, хэнтэй, ямар хэлбэрийн дотно эсвэл бэлгийн харилцаанд орохоо сонгох эрх, эдгээр сонголтоо хариуцлага хүлээх, тус асуудлаарх бусдын сонголтыг хүндэтгэх зэрэг бэлгийн цогц боловсролыг олгох нь урьдчилан сэргийлэх хамгийн чухал арга гэж НҮБ-ын БШУСБ-ын газраас боловсруулсан “Бэлгийн боловсрол олон улсын арга зүйн удирдамж” нотолгоонд суурилсан аргачлалд дурджээ. Мөн өсвөр насны хүүхдэд бэлгийн харилцаанд орох, тэвчих, хойшлуулах сонголт тулгардаг. Бэлгийн харилцаанд орохгүй тэвчих нь жирэмслэлт, БЗДХ (ХДХВ)-ийн халдвараас сэргийлэх чухал арга мөн боловч бэлгийн цогц боловсролын зүгээс тэвчих нь олон залуучуудын амьдралд байнга тогтмол хэрэгжүүлэх зүйл биш бөгөөд залуучууд бэлгийн харилцаагаа зохицуулах арга барил нь наснаас хамаараад ялгаатай байдаг хэмээн хүлээн зөвшөөрдөг. Зөвхөн тэвчихийг дэмжсэн хөтөлбөр өсвөр, залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд ба эрхэд үр дүнгүй, хор уршигтай байж болзошгүйг судлаачид тогтоосон.<sup>33</sup> Хүйсээс үл хамааран хүмүүс хоорондын харилцаа ба мэдрэмжийн талаар мөн бие биетэйгээ харилцсан, хүндэтгэлд суурилсан, бэлгийн дотно харилцааг агуулсан болон агуулаагүй эрүүл харилцааг хэрхэн бий болгох талаар илүү ихийг мэдэхийг хүсдэг байна. Иймээс залуучуудыг бэлгийн мэдрэмжээ өөрийн эрхэмлэдэг үнэт зүйлсэд нийцүүлэн хэрхэн илэрхийлэх арга замуудын тухай бодож эргэцүүлэхийг дэмжихэд анхаарах хэрэгтэй. Бэлгийн харилцаанд орохоор төлөвлөж буй буюу бэлгийн харилцаанд орсон залуучуудын хувьд жирэмслэлт болон БЗДХ-ын эсрэг давхар хамгаалалт болох бэлгэвч гэх мэт жирэмслэлтээс сэргийлэх орчин үеийн арга хэрэгслүүдийн талаар бүрэн хэмжээний мэдээлэлтэй байх чухал<sup>34</sup> буюу бэлгийн цогц боловсролыг олгох шаардлагатай гэдгийг НҮБ-ын БШУСБ-ын газраас зөвлөсөн байдаг.

Гэтэл “Охидын дуу хоолой” судалгаанд сургуульд сургалт үйл ажиллагаагаар дамжуулан нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл хүртээмжтэй чанартай олгодог талаар асуухад 39% нь ерөнхий ойлголтыг өгдөг ч төдийлөн ойлгомжтой биш, 33% нь олгодог ч давтамж нь бага, 29% нь маш сайн олгодог, би нөхөн үржихүйн талаар хангалттай мэдээлэл олж авдаг, 8% нь огт олгодоггүй гэсэн хариултыг өгсөн. Тиймээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр, хүртээмж, чанарт анхаарч, сайжруулах нь урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга байж болох юм.

### с) Охидыг шаардлагагүй үзлэгт оруулснаас үүсэх сөрөг үр дагаврууд

НҮБ-ын Хүний эрхийн хороо, Эмэгтэйчүүдийн байгууллага болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) 2018 онд “охидын үзлэг” (virginity test)-ийг хэрэгцээ шаардлагагүй гэж үзэн халах тухай зөвлөмжүүдийг гаргасан байдаг. “Охидын үзлэг” нь нэг төрлийн жендэрийн ялгаварлан гадуурхалт бөгөөд шинжлэх ухаанч бус нийгэм, соёл болоод шашинтай холбоотой эмэгтэйчүүдийн эсрэг хийгдэж буй жендэрт суурилсан хүчирхийлэл хэмээн үздэг. Охидын үзлэг нь охид, эмэгтэйчүүдийн эрхийн эсрэг хүчирхийлэл болоод зогсохгүй хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн хувьд өнгөрснийг дахин мэдрүүлэх, урт хугацааны туршид дахин сэтгэцийн гэмтэл үүсгэх, дахин хохирогч болох нөхцөлийг үүсгэдэг (re-experience, re-traumatization, re-victimization). Ихэнх эмэгтэйчүүд үүнээс

<sup>33</sup> НҮБ-ын БШУСБ, ТХЗ, “Бэлгийн боловсрол олон улсын арга зүйн удирдамж” нотолгоонд суурилсан аргачлал, УБ 2019 он, 19 дэх тал.

<sup>34</sup> НҮБ-ын БШУСБ, ТХЗ, “Бэлгийн боловсрол олон улсын арга зүйн удирдамж” нотолгоонд суурилсан аргачлал, УБ 2019 он, 19 дэх тал. <https://childrenandaids.org/sites/default/files/202002/International%20technical%20guidance%20on%20sexuality%20education%20an%20evidence-informed%20approach-%20Mongolian.pdf> 2021.04.17-ны өдөр хандав.

үүдэн урт болон богино хугацааны сэтгэл зүйн болоод бие махбодын хямралд өртөхөөс гадна зарим тохиолдолд амиа хорлох, амиа алдах эрсдэлийг хүртэл дагуулдаг. Маш олон хүний эрхийн байгууллагууд энэ нь охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэсэн байр суурьтай байна.<sup>35</sup>

АНУ-ын AJAMA Internal Medicine-аас хийсэн судалгаагаар онцын шаардлага, тодорхой шинж тэмдэг илрээгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх “охидын үзлэг” 21 наснаас доош насныханд хийх нь тохиромжгүй хэмээн үзсэн. Мэргэжилтнүүд БЗДХ өвчнийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт “охидын үзлэг” шаардлагагүй хэмээн дүгнэсэн.<sup>36</sup>

### 1.3 “Охидын үзлэг”-ийг зохион байгуулж буй эрсдэлтэй орчин

ЭМС-ын 2017 болон 2020 оны тушаалаар баталсан журмуудын дагуу бол өсвөрийн кабинет болон бүх шатны эмнэлгийн байгууллагад “охидын үзлэг”-ийг зохион байгуулж байхаар тусгасан ч бодит байдал дээр эмнэлгийн зориулалтын орчинд охидын үзлэгийг зохион байгуулахгүй байгаа судалгааны үр дүн, тохиолдлууд байна.

#### Тохiolдол 4.

- ... аймагт өсвөр үеийн кабинетаар дамжуулан 2018-2020 онд 324 урьдчилан сэргийлэх үзлэгт **240 хүүхдийг хамруулан** 28 хүүхдийг хэвтүүлэн эмчлүүлсэн.
- 2019-2020 онд БСУГХГБЗХГ, сум 8 өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран 3 удаа өсвөр үеийн охид, хөвгүүдийн үзлэгийг зохион байгуулж, ЕБС-д суралцаж байгаа **16-18 насны 2326 охидын эрүүл мэндийн 82-92 %-ийг хамруулж**, жирэмсэн 8, тэмбүүтэй илэрсэн 8 тохиолдлыг хяналтад авч, хавьтагчийн хамт эмчилж, НҮЭМ-ийн боловсрол олгох сургалтад хамруулсан тухай мэдээллийг холбогдох газрын мэргэжилтэн мэдээлсэн. Тус мэдээллийн дагуу охидын үзлэгийг хэрхэн зохион байгуулсан тухай тодруулахад:
  - Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан ЕБС-д суралцдаг охидын үзлэгийг зохион байгуулсан тухай мэдээлсэн.

Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он

Дээрх тохиолдолд дурдсан мэдээллийг нягталж үзвэл өсвөрийн кабинетаар дамжуулан 240 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан гэсэн бол, ЕБС-ын 2326 охидын 82-92%-ийг үзлэгт хамруулсан хэмээн дурдсан буюу эдгээр охидыг зориулалтын эмнэлгийн байгууллагад үзлэгт оруулсан эсэх нь эргэлзээтэй байгаа.

<sup>35</sup> WHO, United Nations agencies call for ban on virginity testing [https://www.who.int/news/item/17-10-2018-united-nations-agencies-call-for-ban-on-virginity-testing?fbclid=IwAR2miikD0gpjHA5FLpAGI\\_EoF2naCCJGyTLK-MIrunVfhMpTzXRrPJ3KPPQ](https://www.who.int/news/item/17-10-2018-united-nations-agencies-call-for-ban-on-virginity-testing?fbclid=IwAR2miikD0gpjHA5FLpAGI_EoF2naCCJGyTLK-MIrunVfhMpTzXRrPJ3KPPQ) 2021.04.17-ны өдөр хандав.

<sup>36</sup> Qin, J., Saraiya, M., Martinez, G., & Sawaya, G. F. (2020). Prevalence of potentially unnecessary bimanual pelvic examinations and Papanicolaou tests among adolescent girls and young women aged 15-20 years in the United States. *JAMA internal medicine*, 180(2), 274-280

**а) Сургуулийн орчинд хийгдэж буй “охидын үзлэг”-ийн асуудал**

Судалгааг эхлэх үед “Хөөрхөн Зүрх” ТББ-аас 2021.03.02-ны өдөр ЭМСайд С.Энхболд<sup>37</sup>, ХЭҮК-ын гишүүн, даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч Ж.Хунан, БШУСайд Л.Энх-Амгалан<sup>38</sup> нарт хандан ХЭҮК-ын 2019.06.04-ний өдрийн 01/30 дугаар зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаар тодруулах албан бичгийг тус бүр хүргүүлж, хариу хүссэн байдаг.

БШУЯ-наас 2021.03.12-ны өдрийн 6/1156 тоот “Хариу хүргүүлэх тухай” албан бичгээр<sup>39</sup> “...Охидын үзлэгийг ерөнхий боловсролын сургуулийн орчинд зохион байгуулах нь эрүүл мэндийн шаардлага хангахгүй улмаас хүний эрхийн ноцтой зөрчил хэмээн үзэж Эрүүл мэндийн яамнаас чиглэл болгосны дагуу 2015 оноос энэхүү үзлэгийг сургуулийн орчинд зохион байгуулаагүй болно...” гэж дурдсан байна.

ХЭҮК-оос 2021.03.10-ны өдрийн 6/294 дүгээр албан бичгээр ХЭҮК-ын 2019.06.04-ний өдрийн 01/30 дугаар зөвлөмжийн дагуу ЭМЯ-аас ирүүлсэн хариуг хуулбарлан ирүүлсэн.<sup>40</sup> ЭМЯ-наас албан бичгийг хариуд ямар нэгэн хариуг бидэнд ирүүлээгүй бөгөөд ЭМЯ-нд “охидын үзлэг”-тэй холбоотой асуудлаар удаа дараа хандаж байсан ч албан ёсны хариуг одоог хүртэл өгөөгүй байна.

“Хөөрхөн зүрх” ТББ, “ГҮНЖ” төвөөс 2021.01.26-ны өдөр хамтран зохион байгуулсан “Сургууль ба Охидын үзлэг” мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэг ЭМЯ болон БШУЯ-наас төлөөлж оролцсон мэргэжилтнүүд “охидын үзлэг”-тэй холбоотойгоор дараах мэдээллийг өгсөн. Үүнд:

*ЭМЯ-ны Өсвөр үе, хүүхэд, залуучуудын нөхөн үржихүй, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн:*

- Эрүүл мэндийн салбарт өсвөр үеийнхэнд ээлтэй орчин бүрдүүлэх үйл ажиллагаануудыг дараах тушаал, журмын дагуу зохион байгуулж байна:
- ЭМС-ын 2017 оны А/399 дүгээр тушаалаар Өсвөр үеийн эмчийн ажлын байрны тодорхойлолт, хийх ажлын чиглэл, эрүүл мэндийн кабинет байгуулж, үйл ажиллагаа явуулах харилцааг зохицуулсан.
- ЭМС-ын 2015 оны 224 дүгээр тушаал: Өсвөр үеийн эрүүл мэндийн мэдээллийг аймаг нийслэлийн дүүргийн өсвөр үеийн кабинетаас ЭХЭМҮТ-ийн өсвөр үеийн эрүүл мэндийн /лавлагаа клиник/ төвд цахимаар хүлээн авах, хянах тогтолцоо бүрдүүлсэн.
- ЭМС-ын 2020 оны А/364 дүгээр тушаал: “Охидод эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх болон өсвөр насны жирэмслэлтэд тусламж үйлчилгээ үзүүлэх заавар”-ыг баримтлан стандарт, дүрэм журмыг хэрхэн баримтлах дэлгэрэнгүй оруулж өгсөн тушаал байгаа. Сургуулийн орчинд нөхөн үржихүйн үзлэг хийдэггүй. Охидын эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хандсан хүсэлтийн дагуу эмнэлэгт үзлэгийг хийдэг.

<sup>37</sup> Судалгааны хавсралт-1-т албан бичгийг хавсаргав.

<sup>38</sup> Судалгааны хавсралт-3-т албан бичгийг хавсаргав.

<sup>39</sup> Судалгааны хавсралт-4-т хариу албан бичгийг хавсаргав.

<sup>40</sup> Судалгааны хавсралт-5-т хариу албан бичгийг хавсаргав.



*БШУЯ-ны Хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан мэргэжилтэн:*

- Сүүлийн 2, 3 жилд охидын үзлэг хийхгүй байгаа. Харин ЕБС-иуд дээр томуу, төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын аяныг хийж байгаа. Эмч нар дээр суурилан “Урьдчилан сэргийлэх үзлэг”-ийг үндэсний хэмжээнд хийж байна. Тодорхой хэдэн аймгууд аймгийн болон эрүүл мэндийн байгууллагууд дээр охидын үзлэгийг хийж байгааг үгүйсгэхгүй.

ЭМЯ болон БШУЯ-наас 2015 оноос хойш сургуулийн орчинд “охидын үзлэг”-ийг зохион байгуулаагүй, өсвөр үеийн кабинетаар дамжуулан өсвөр үеийнхэнд ээлтэй байдлаар зохион байгуулж байгаа гэх мэдээллийг өгдөг, байр сууриа хамгаалж байгаа ч бодитой тохиолдлууд тасрахгүй байгаа билээ. ХЭҮК-ийн “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл”-д “...Гэвч зарим аймаг, орон нутагт ерөнхий боловсролын сургуульд “охидын үзлэг”-ийг нэгдсэн байдлаар зохион байгуулж байгаагаас үүдэн өсвөр насныхны эрүүл мэндийн нууцаа хамгаалуулах эрх зөрчигдөж, сургууль болон гэр бүлийнхээ орчинд гутаан доромжлол, ялгаварлан гадуурхалтад өртөж буй талаарх мэдээлэл Комисс-т ирж гарч байна...”<sup>41</sup> гэдгийг дурдсан байдаг.

*Дархан-Уул аймгийн “Од” цогцолборын тохиолдол<sup>42</sup>*

#### **Тохиолдол 5.**

2019 оны 10-р сарын 29-ны өдөр Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын “Од” цогцолбор сургуулийн захиргаанд охид, залуу эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах “ГҮНЖ” төв, “Өөрчлөлтийн төлөө эмэгтэйчүүд” ТББ, “Хөөрхөн зүрх” ТББ-аас тус сургуульд ахлах ангийн охидыг өөрсдийн болон эцэг, эхийн тодорхой зөвшөөрөлгүйгээр, нийтээр нь албадан бие махбодын болон халдашгүй байдалд халдаж эрүүл мэндийн гэх үзлэг явуулах гэж байгаа тухай мэдээллийн дагуу хандаж “охидын үзлэг”-ийг зогсоох тухай хүсэлтийг хүргүүлсэн байдаг.<sup>43</sup>

Дээрх хүсэлтийн дагуу Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын “Од” цогцолбор сургуулийн захирал Х.Баярбилэг, сургуулийн эмч Д.Отгонзул, Эрүүл мэндийн төвийн НЭМТ-ийн дарга С.Энхжаргал нар орон нутгийн [www.mydarkhan.mn](http://www.mydarkhan.mn) гэх вэб сайтад ярилцлага өгч охидын өөрийн болон эцэг, эхийн зөвшөөрлийн үндсэн дээр “Амин холбоо” өрхийн эрүүл мэндийн төвөөс аймгийн эрүүл мэндийн газрын А/29 дугаар тушаалын дагуу аймгийн ЭМГ, Нэгдсэн эмнэлэг хамтран халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэг оношилгоо хийх 9-11 дүгээр ангийн охидын үзлэгт 15-аас дээш насны 13, 15, 16 дугаар багт харьяалагдах багш, сурагч, ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэг хамруулахыг хүссэн<sup>44</sup>, сургууль дээр “охидын үзлэг” зохион байгуулаагүй хэмээн тайлбарласан байна. Сургуулийн эмч жил бүр охидын үзлэгийг эрүүл мэндийн газраас хийдэг, бусад сургуулиуд дээр ч явагддаг гэсэн ярилцлага өгсөн.

Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор “Монфемнет” Үндэсний сүлжээ байгууллага, “Хөөрхөн Зүрх” ТББ, “ГҮНЖ” Төв, “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-ууд хамтран зарим орон нутгийн Ерөнхий Боловсролын Сургууль дээр нийтээр нь албадан, охидын болон эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр бие махбодын, бэлгийн халдашгүй дархан байдалд халдан эрүүл мэндийн охидын үзлэг явуулдаг байж болзошгүй мэдээллийн дагуу 2019.10.30-ны өдрийн 03/19 тоот албан бичгээр ХЭҮК-т хандсан байдаг. ХЭҮК-оос 2019.11.28-ны өдрийн 4/722 тоот албан бичгээр УИХ-ын 2019 оны 62 дугаар “Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын Д, З, М хэсгүүдэд хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал, ялгаварлан гадуурхах зэрэг асуудлыг

<sup>41</sup> ХЭҮК “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл”-ийн 114 дэх тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=758> 2021.04.05-ны өдөр хандав.

<sup>42</sup> <https://www.mydarkhan.mn/a/274> 2021.03.28-ны өдөр хандав.

<sup>43</sup> <http://peak.mn/news/gunj-tuw-okhidiin-uzlegiig-zogsookhiig-shaardlaa> 2021.04.10-ны өдөр хандав.

<sup>44</sup> Судалгааны хавсралт-6-д “Од” цогцолбор сургуульд ирүүлсэн албан бичгийн хувь

сургуулийн орчинд буруулах, мөн эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлийг тусгасан. ХЭҮК-оос ЭМС-д 2019.06.04-ний өдрийн 1/30 дугаар зөвлөмжийг хүргүүлж ажиллаж байгаа талаар дурдан ирүүлсэн байдаг.

Энэхүү судалгааг эхлүүлээд мэдээлэл цуглуулах явцад С аймгийн ЕБС-ийн ахлан ангийн сурагчдаас “Хөөрхөн зүрх” ТББ, “ГҮНЖ” төв ТББ-д холбогдож “охидын үзлэг” зохион байгуулагдах гэж байгаа талаар мэдээлэл өгсөн, үүний дагуу “охидын үзлэг”-ийг таслан зогсоох арга хэмжээ авч ажилласан байна.

*С аймагт сургуулийн орчинд “охидын үзлэг” зохион байгуулсан тохиолдол:*

**Тохиолдол 6.**

2021 оны 3-р сарын 11-ний өдөр С аймгийн нэгэн суманд өсвөр насны охидыг зөвшөөрөлгүйгээр эрүүл мэндийн үзлэгт оруулж, жирэмсэн эсэхийг тодорхойлох тестийг шээсэнд нь дүрэх аргаар охидын хүнтэй унтсан эсэх, жирэмсэн эсэхийг тодруулах үзлэг хийх гэж буйг тус сургуулийн сурагчид мэдээлсэн. Тус сурагчид сургуулийн удирдлага, багш, нийгмийн ажилтнуудад хандан үзлэгт орохгүй байх хүсэлтээ илэрхийлсэн ч сургуулийн зүгээс хүчээр оруулахаар охидыг шаардаж буй талаар “Хөөрхөн Зүрх” ТББ, “ГҮНЖ” Төв-рүү холбогдон мэдээлж, эмнэлгийн кабинетад зохион байгуулж байгаа хэдий ч эрүүл ахуй, аюулгүй байдал, нууцлалын асуудлыг бүрэн хангаагүй нөхцөлд хийх гэж буйг баримтаар гаргасан.

**Тохиолдол 7.**

Тус асуудлын дагуу С аймгийн дээр дурдсан сумын сургуулийн нийгмийн ажилтантай холбогдож нөхцөл байдлыг тодруулахад охид болон хөвгүүдийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад жижиг, сум орон нутаг учир эрүүл мэндийн стандарт, хангасан үйлчилгээг үзүүлэхэд хүндрэл бэрхшээлтэй байдаг бөгөөд өсвөр үеийнхний эрүүл мэндийн үзлэгийг зөвшөөрөл авсны үндсэн дээр хийх шаардлагатай гэдэг мэдлэг, мэдээлэлгүй байсан.

*Эх сурвалж: “Хөөрхөн зүрх” ТББ, “ГҮНЖ” төв-д ирүүлсэн баримт, 2021.03 сар*

Дээрх тохиолдолтой ойролцоо нөхцөл асуудлыг Б аймгийн холбогдох мэргэжилтэн “Хөөрхөн зүрх” ТББ, “ГҮНЖ” төв ТББ-аас зохион байгуулсан хэлэлцүүлэгт дурдсан байдаг.

**Тохиолдол 8.**

Б аймгийн холбогдох мэргэжилтний зүгээс сүүлийн 2 жилийн хугацаанд “охидын үзлэг”-ийг улсын хэмжээнд зохион байгуулахгүй байх талаар бодлого баримталж байгаа. Охидын “шээс”-нд тест хийх аргаар үзлэгийг зохион байгуулдаг тухай дурдав.

*Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он*

**в) Бусад эрсдэлтэй орчин**

Одоогийн байдлаар “Сургуулийн дотуур байр” болон “Асрамжийн газрууд”-ын нөхцөл байдлыг судалж үзсэн судалгаа хийгдээгүй байна. Гэхдээ судалгаа хийгдээгүй, мэдээлэл байхгүй байлаа гээд “охидын үзлэг”-ийг хийхгүй байгаа гэж ойлгож болохгүй. Учир “Сургуулийн дотуур байр” болон “Асрамжийн газруудын” нь мэдээлэл хаалттай, мөн эсхүл алслагдсан орон нутагт байдаг зэргээс хамаарч байж болох юм.

Хамгийн сүүлд гэхэд 2014 онд НҮБ-ХС, ХТҮГ “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хамгаалагдах эрхийн нөхцөл байдал” судалгаанаас үзэхэд “Хамтарсан багийн гишүүдийн бүлгийн ярилцлагын мэдээллийн дүн шинжилгээ” хэсгээс дараах үр дүнг онцолж байна. **Дотуур байранд амьдарч буй хүүхдүүдийн хамгаалагдах эрхийн хэрэгжилттэй холбоотой тулгамдсан асуудлууд хэсэгт дурдсанаар:**

- Дотуур байр эмчгүй
- Сургуулийн эмч тэр бүр хүрч ажилладаггүй
- Нууцлалыг хадгалж чаддаггүй
- Хүүхэд хамгааллын мэдлэг сул
- Сургуулийн захиргаа дотуур байрандаа анхаарал сул тавьдаг

#### Тохиолдол 9.

Зарим эрэгтэй хүүхэдтэй үерхдэг охид жирэмслэх, хүүхдээ төрүүлэх тохиолдол байдаг л юм. Гэхдээ энэ бол сонин биш ээ.....

*Эх Сурвалж: МСҮТ-ийн 1.2-р дамжааны эмэгтэй сурагчдын бүлгийн ярилцлагаас<sup>45</sup>*

2014 оноос хойш сургуулийн дотуур байрны хүүхдийн эрхийн асуудлаар тодорхой судалгаа хийгдээгүй, мөн дотуур байрны охидын эрхийн асуудал, “охидын үзлэг”-тэй холбоотой асуудлаар нарийвчилсан судалгаа хийж, охидын эрхийн зөрчил байгаа эсэхийг судалж үзэх шаардлагатай, эрсдэлтэй орчин гэж үзэж байна.

Асрамжийн газарт хүүхэдтэй холбоотой нийгмийг цочроосон мэдээллүүд гарах болсон. Асрамжийн газар дахь хүүхдийн эрхийн хамгаалал, охидын бэлгийн халдашгүй байдал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн болон аюулгүй байдлын асуудал, охидын үзлэг зэрэг асуудлыг нарийвчлан судалж үзэх шаардлага үгүйлэгдэж байна.

#### 1.4 ЭМС-ын тушаалуудын хууль зүйн хүчин чадал

ЗЕХ-ийн 59 дүгээр зүйлд заасны дагуу хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг захиргааны хэм хэмжээний акт гэж ойлгохоор тусгасан.

ЭМС-аас 2017 оны А/399, 2020 оны А/364 тушаалыг тус тус баталж охидын үзлэг зохион байгуулах харилцааг зохицуулж өгсөн. ЭМС-ын 2 тушаалын эрх зүйн үндэслэлийг судалж үзвэл ЗГТХ-ийн 24.2 буюу Монгол Улсын сайд эрх хэмжээний асуудлаар хууль, УИХ тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж биелэлтийг хангана, ЭМТХ-ийн 8.1.1-т заасны дагуу эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах гэсэн зохицуулалтыг үндэслэжээ. Дээрх ЗГТХ-ийн 24.2, ЭМТХ-ийн 8.1.1 дэх хэсэг нь ЭМС-ын тушаал гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах эрх хэмжээтэй гэдгийг тусгаж өгсөн ерөнхий зохицуулалт байна.

<sup>45</sup> ХТҮГ, НҮБ-ын ХС “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хамгаалагдах эрхийн нөхцөл байдал” судалгааны тайлан, УБ хот, 2014 он, 28 дахь тал.

ЭМС-ын 2017 оны А/399 тушаалд ЗХДтХ-ийн 10.1.3<sup>46</sup>, 10.2<sup>47</sup> дахь заалтыг үндэслэсэн байна. Эдгээр зохицуулалтад өсвөр залуу үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээ нэвтрүүлэх, арга хэмжээг хэрэгжүүлэгч үүргийг ЭМЯ-наас хариуцна гэж тусгасан буюу хэм хэмжээний акт батлах тусгайлсан зохицуулалт тусгагдаагүй байна.

ЭМС-аас 2017 оны А/399, 2020 оны А/364 дүгээр тушаалын аль алинд нь Засгийн газрын 2017 оны 78 дугаар “Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн 3.2.3.1 дэх заалтыг үндэслэсэн байдаг. Үндэсний хөтөлбөрийн 3.2.3.1-т “өсвөр үе, залуучуудад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний заавар, журмыг шинэчлэн боловсруулах” гэж тусгасан байна. Гэтэл ЗЕХ-д тухайн захиргааны байгууллага, албан тушаалтан хэм хэмжээний акт гаргахын тулд УИХ-аас баталсан хуулиар тусгайлан эрх олгогдсон байхыг шаарддаг. Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт гаргах эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглодог бөгөөд Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу ЭМС-аас хэм хэмжээний акт баталж нийтээр дагаж мөрдүүлж байгаа нь ЗЕХ-ийн 59 дэх заалтыг зөрчсөн үйлдэл болно.

ЗЕХ-ийн 16 дугаар бүлэгт хэм хэмжээний актыг батлахтай холбоотой төсөл бэлтгэх, боловсруулах, төсөлд санал өгөх, хэм хэмжээний актыг батлах, хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. ХЗДХЯ-наас Засгийн газрын баталсан хэм хэмжээний актаас бусад хэм хэмжээний актын бүртгэлийг хийдэг бөгөөд ЗЕХ-д заасан шаардлага хангаагүй хэм хэмжээний актыг бүртгэхгүй байх эрхтэй. ХЗДХЯ-ны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэгдээгүй тохиолдолд хүчин төгөлдөр болж, нийтээр дагаж мөрдөгдөх боломжгүй юм.

Энэхүү судалгааны хүрээнд ЭМС-ын 2017 оны А/399, 2020 оны А/364 тушаалуудыг ХЗДХЯ-ны хэм хэмжээний актад бүртгэлтэй эсэхийг шалгаж үзсэн ч судалгааг гүйцэтгэх үед бүртгэгдээгүй байсан.

## 1.5 Бүлгийн дүгнэлт

Үндсэн хууль болон олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалж, ардчилсан нийгмийн тулгуур хүний хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцохгүй, өөртэй нь холбоотой асуудлыг шийдвэр гаргах, хүүхэд санал, хүслийг шийдвэр гаргахад харгалзаж үзэх, амьдралаа төлөвлөх, шийдвэр гаргах зэрэг цогцолбор эрхийг ойлгодог байна.

Нөгөө талаас эрүүл мэндээ хамгаалуулах, чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд өсвөр үеийнхэнд бэлгийн бойжилт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хамгаалахаар аливаа урьдчилсан сэргийлэх үзлэг, оношилгоо хийдэг.

Гэхдээ эрүүл мэндийн аливаа үзлэг, оношилгоо, үйлчилгээ үйлчлүүлэгчийн зөвшөөрөл, хүсэлтийн үндсэн дээр явагддаг. Гэтэл “охидын үзлэг”-ийг хүүхдийн зөвшөөрөл авалгүйгээр хүчээр, зориулалтын бус орчинд, нийтээр нь зохион байгуулдаг байж болзошгүй тохиолдол,

<sup>46</sup> ЗХДтХ-ийн 10.1.3.өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, цахим эрүүл мэндийн үйлчилгээг нэвтрүүлэх;

<sup>47</sup> ЗХДтХ-ийн 10.2.Энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5, 10.1.6-д заасан арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

судалгааны үр дүнгүүд гарч байна. Олон Улсын байгууллагуудаас шаардлагагүй “охидын үзлэг”-ийг зохион байгуулахын эсрэг байр суурьтай байдаг бөгөөд зогсоохыг уриалдаг. Зөвшөөрөлгүй, хүчээр “охидын үзлэг”-г оруулснаар өсвөр насны хүүхдэд сэтгэл зүйн сөрөг үр дагавар үүснэ гэдгийг судлаачид онцгойлон дурдаж, таслан зогсоох шаардлагатай гэж үзсэн байдаг.

Хүчээр, нийтээр нь албадан, сургуулийн орчинд “охидын үзлэг”-ийг хийдэг гэдэг нь бодит тохиолдол, социологийн судалгааны үр дүн зэргээр баталгаажиг байна. Салбарын бодлого тодорхойлогч ЭМЯ, БШУЯ-наас 2015 оноос хойш сургуулийн орчинд “охидын үзлэг” зохион байгуулаагүй гэсэн тайлбар ирүүлдэг. Гэвч анхан шатанд ажилладаг мэргэжилтнүүд цагдаа, прокурор, эмнэлгийн шаардлагаар зохион байгуулахаас өөр аргагүй байдаг гэдгээ мөн тайлбарладаг.

Охидын үзлэгийг зайлшгүй шаардлага, сайн дурын үндсэн дээр зөвхөн эмнэлгийн орчинд зохион байгуулах ёстой. Өнөөгийн практикт хэрэгжиж буй шиг зарим цагдаа, прокурор, эмнэлгийн байгууллагын шаардлага, эсхүл статистик мэдээ хөтлөх зорилгоор зохион байгуулах явдлыг таслах, зогсоох шаардлагатай байна. Цаашид бусад эрсдэлтэй орчинд социологийн болон бусад суурь судалгааг хийж охидын үзлэгийг зохион байгуулж буй эсэх, охидын эрхийн зөрчил үүсэж байгаа эсэхийг тодруулах нь зайлшгүй шаардлагатай байна.

## Хоёр. ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ХАМГААЛАЛТ БА “ОХИДЫН ҮЗЛЭГ”

### 2.1. Хувь хүний нууцын хамгаалалт

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11/ ...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална, 13/ Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц... хуулиар хамгаална; 17/...Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална, **мөн 19 дүгээр зүйлийн 1/Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцана гэж заасны дагуу хувь хүний нууцыг хамгаалах нь төрийн бүхий л эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын зүгээс өөр өөрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх арга, чиг үүргийн дагуу эрх, эрх чөлөөг хангахуйц баталгааг ажил хэрэг болгохыг ойлгоно.**<sup>48</sup>

Үүний дагуу ХХНтХ-ийн 4 дүгээр зүйлд 1/захидал харилцааны нууц, 2/эрүүл мэндийн нууц, 3/ хөрөнгийн нууц, 4/гэр бүлийн нууц, 5/хуулиар тогтоосон бусад нууцыг хамгаалахаар тусгасан.

ХХНтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2-т Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараах утгаар ойлгоно:2/эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг, 4/гэр бүлийн нууцад бусдад задруулбал тухайн хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн нэр төр, алдар хүнд, ашиг сонирхолд харшлах мэдээллийг хамааруулахаар байна.

Хувь хүн нууцаа өөрөө хамгаалах, хувь хүний нууцыг хуулийн дагуу болон итгэмжлэлээр олж мэдсэн этгээд бусдад задруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд хувь хүний нууцыг хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу төр, байгууллага хамгаалалтдаа авч болохоор тусгасан.

Түүнчлэн хувь хүний нууцын төрлийг тогтоож, хувь хүний нууцыг ил болгох үндэслэл, энэ хуулиар хамгаалсан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах эрх болон хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулсан нь Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад томоохон хувь нэмэр оруулсан хэдий ч нийгмийн харилцаа тасралтгүй хөгжиж байгаа энэ цаг үед нийгэмд үүсээд байгаа зарим төрлийн асуудлыг зөвхөн ХХНтХ-иар зохицуулахад бэрхшээлтэй нөхцөл байдлууд үүссээр байгаа<sup>49</sup> гэж үзсэн учир ХЗДХЯ-наас “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн<sup>50</sup> байна.

<sup>48</sup> Ц.Цогт “Үндсэн хуулийн “...төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм...-ийн баталгааг бүрдүүлэх” зохицуулалтын товч тайлбар <https://legaldata.mn/buteel/pdf?id=337> 2021.03.27-ны өдөр хандав.

<sup>49</sup> Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/02/%D2%AE%D0%B7%D1%8D%D0%BB%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D0%BB.pdf> 2021.04.17-нд хандав.

<sup>50</sup> <https://mojha.gov.mn/newmojha/?topic=%d1%85%d2%af%d0%bd%d0%b8%d0%b9%d1%85%d1%83%d0%b2%d0%b8%d0%b9%d0%bd%d0%bc%d1%8d%d0%b4%d1%8d%d1%8d%d0%bb%d1%8d%d0%bb%d1%85%d0%b0%d0%bc%d0%b3%d0%b0%d0%b0%d0%bb%d0%b0%d1%85-%d1%82%d1%83%d1%85%d0%b0> 2021.04.17-нд хандав.

ХХНтХ-иар зохицуулахад агуулга нь хэт ерөнхий, тунхаглалын шинжтэй, тодорхой төрлийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа тул “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийн төслөөр зарим төрлийн үйлчилгээний газрууд хэрэглэгчийн худалдан авалтын үнийн дүнд суурилсан оноо цуглуулах, хувь хүний таньж баталгаажуулах зорилгоор иргэний биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) болон хувь хүний бусад мэдээлэл цуглуулах нь түгээмэл байгаа бөгөөд ингэхдээ хүний хувийн мэдээллийг тухайн хувь хүнд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авалгүйгээр цуглуулах, анх цуглуулсан зорилгоос өөр зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, хүний хувийн мэдээлэл алдагдах эрсдэл үүссэн тохиолдолд эргэн мэдэгдэх, мэдээллийн аюулгүй байдал хамгаалах зэрэг асуудлыг зохицуулах, дүрс бичлэгийн төхөөрөмжийг байршуулахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй, түүнд тавигдах шаардлагыг тодорхойлоогүй, хориглох зохицуулалт байхгүй, хяналт тавьдаггүй зэрэг асуудлууд байгаа гэж үзэж боловсруулсан байна.<sup>51</sup> Хуулийн төсөлд “эрүүл мэндийн мэдээлэл” гэж хувь хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээллийг хамааруулахаар тусгаж өгсөн байна.

“Охидын үзлэг”-т орсон талаарх мэдээлэл ХХНтХ-ийн “эрүүл мэндийн нууцад” хамаарахгүй байгаа бөгөөд гэр бүлийн бусдад задруулбал сөрөг үр дагавар үүсэж болох нууцад үзлэгийн үр дүн хамаарч болохоор байгаа. Гэхдээ хувь хүн “охидын үзлэг”-т орсон талаарх мэдээллээ бусдад мэдэгдэхийг хүсэхгүй байгаа нөхцөлд өнөөгийн хуулийн орчинд хамгаалахад хүндрэлтэй байна.

#### **a) Хувь хүний нууцыг ил болгох үндэслэл**

ХХНтХ-д 6 дугаар зүйлийн Хувь хүний нууцыг ил болгох хэсэгт Монгол Улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, иргэдийн эрүүл мэнд, хууль ёсны эрх ашигт хохирол учруулахгүйн үүднээс зайлшгүй шаардлагатай онцгой тохиолдолд төрийн холбогдох эрх бүхий байгууллага /албан тушаалтан/-ын шийдвэрээр хувь хүний эрүүл мэндийн болон бусад нууцыг хуульд заасан хүрээнд ил болгож болно гэж тусгаж өгсөн.

Мөн Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө гэдгийг тусгасан.

#### **b) Бусад хууль тогтоомжийн зохицуулалт**

ХЭтХ-ийн 7 дугаар зүйлийн “Хүүхдийн хамгаалуулах эрх”-ийн 7.3-т “Хүүхэд өөрийн нэр төр, гэр бүлийн амьдрал, эрүүл мэнд, хувийн харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал, хувийн орон зайгаа хамгаалуулах эрхтэй” хэмээн тодорхой зохицуулж тусгасан.

ХХтХ-ийн 7 дугаар зүйл “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх хүүхэд хамгаалал” 7.2-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан

<sup>51</sup> Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал

тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна” гэж зохицуулсан байна.

ЭМС-ын 2017 оны А/399 дугаар тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багц”-ын 2.3-д Эрүүл мэндийн ажилтнууд өсвөр үеийн кабинетаар үйлчлүүлсэн өсвөр үеийнхэн, залуучуудын хувийн нууцыг хадгална. Журмын 6-д Бэлгийн замаар дамжих халдварууд (БЗДХ) 4.1-д Бэлгийн замаар дамжих халдвар илрүүлэх үзлэг хийхдээ нууцыг чандлан хадгалах болно гэдгээ урьдчилан хэлнэ гэж тусгаж өгсөн байдаг.

ЭМС-аас 2020 онд А/364 дүгээр тушаалын дагуу батлагдсан “Охидын эрүүл мэндийн өвөрмөц тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар” 1.2-д үйлчлүүлэгчийн бүртгэл, мэдээлэл, ярилцлагын тэмдэглэлийн нууцлал, аюулгүй байдлыг хадгална, “Өсвөр насны жирэмсэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар” 2.2-д хувийн нууцыг хуулийн хүрээнд чандлан хадгална гэж тус тус зохицуулсан байдаг.

ЭМС-ын 2019 оны А/406 дугаар тушаалын 1-р хавсралт “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн аль алинд “нууцыг хадгалах” хэмээн заасан ч ямар хэмжээнд хэрхэн хадгалах журам нь тодорхойгүй харьцангуй эргэлзээтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

- 3.3-д Хүндэтгэлтэй хандах зарчмын хүрээнд: Хүний язгуур эрхийг хүндэтгэн хамгаалах, сонсох, өөрийн бодол санааг зөв ойлгуулах, хүлээцтэй харилцах, эелдэг, даруу төлөв байх, нууцыг хадгалах;
- 4.5-д Өвчний түүх болон үйлчлүүлэгчийн нууцтай холбоотой бичиг баримтыг үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах буюу ашиглуулахгүй байх гэж тусгагдсан байдаг.

#### Тохиолдол 10.

2018 онд ..... аймгийн Прокурорын газраас “Нуугдмал” нэртэй аяныг зохион байгуулсан. Аймгийн төр болон хувийн хэвшлийн эмнэлгүүдэд үйлчлүүлж байсан 18-с доош насны жирэмсэн, үр хөндүүлсэн, БЗДХ өвчнөөр өвдөж эмчлүүлсэн хүүхдүүдийн мэдээлэлтэй танилцах ажиллагааг зохион байгуулсан байна.

*Эх сурвалж: “Сургууль ба Охидын үзлэг” Үндэсний хэлэлцүүлэг, 2021 он*

Дээрх тохиолдолд дурдсаны дагуу Прокурорын байгууллагаас шаардсан нөхцөлд хувь хүмүүсийн нууц мэдээллийг өгсөн нь хүний хувийн нууцын хамгаалалт, хууль эрх зүйн мэдлэг ямар хэмжээнд байгааг харуулж байна. Прокурорын байгууллага тухайлсан хэргийн асуудлаар хувь хүн, байгууллага, албан тушаалтнаас гэмт хэрэг илрүүлэх зорилгоор хувийн нууцтай танилцах, мэдээлэл авах эрхтэй байж болох ч аян өрнүүлж байгаа гэх нэрээр охидын эрүүл мэнд, хувийн нууцтай танилцах, мэдээлэл цуглуулах асуудал нь ХХНтХ, ЭМС-ын баталсан журмуудын хэрэгжилт ямар хэмжээнд байгаа гэдгийг шууд харуулж байна.



### е) Хувь хүний нууцыг хамгаалах процессыг тодорхой тусгах

Ажлын шаардлагаар хувь хүний нууцтай танилцаж байгаа нөхцөлд үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчийн үзлэгийн үр дүн нууцлах үүргийг үйлчлүүлэгчийн өмнө хүлээдэг учраас үйлчлүүлэгчид нь тухайн асуудалтай холбоотой бүхий л мэдээлэл, ялангуяа хагийн дотнын хүндээ ч хуваалцахыг хүсдэггүй, бусдад мэдэгдвэл таагүй байдалд орох мэдээллийг хуваалцдаг бөгөөд үүний үндсэн дээр үйлчилгээгээ явуулдаг. Эдгээр мэргэжилтэн нууц хадгалах үүргээ зөрчвөл ёс зүйн зөрчилд тооцогдож сахилгын шийтгэл хүлээдэг. (бусад хариуцлага мөн хүлээнэ)

Эдгээр мэргэжилтний нууц хадгалах үүргээ биелүүлэх баталгааг “охидын үзлэг” зохион байгуулах журамд, хуулиуд нарийвчлан суулгаж өгөх, тухайн мэргэжилд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалдаг, улмаар үүгээр нийтийн ашиг сонирхол хамгаалагддаг.<sup>52</sup>

ЭМС-ын 2019.07.04-ны өдрийн 12 дугаартай “Хүүхдийн эрүүл мэнд, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай” албан даалгаврын<sup>53</sup> 2.3-т ЭМС-ын 2018 оны “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах тухай” 480 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах гэж дурдсан байдаг.

Гэвч ЭМС-ын 2018 оны “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах тухай” 480 дугаар тушаалыг эрх зүйн мэдээллийн [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) болон ЭМЯ-ны албан ёсны цахим хуудсаар хайлт хийж үзсэн ч олж чадаагүй. Хэрвээ “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах тухай” журам нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бол ил тод биш, журамтай танилцах боломж хангалтгүй, харин хүчингүй болсон бол нөхөж ямар журам гарсан талаар мэдээлэл байхгүй байна.

Хэдийгээр хувь хүний нууцыг хамгаална, чандлан хадгална гэж тусгагдсан ч хэрхэн хамгаалах талаар тодорхой зохицуулалт байхгүй, ЭМС-ын 2018 оны “Эрүүл мэндийн үйлчилгээн дэх эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар мэдээлэх, нууцыг хадгалах тухай” 480 дугаар тушаал нь нээлттэй биш, мөн “охидын үзлэг”-тэй холбоотой харилцаанд хамаарах эсэх нь мөн тодорхойгүй тул дүгнэлт өгөх боломжгүй байна.

ЭМС-ын 2017 оны А/399 болон 2020 оны А/364 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журмуудад хувийн нууцыг хадгална, задруулж болохгүй гэдэг ерөнхий зохицуулалт байгаа ч нууцыг хадгалах, хамгаалахтай холбоотой нарийвчилсан процессын зохицуулалт хангалтгүй байна.

<sup>52</sup> О.Мөнхсайхан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар халдашгүй, чөлөөтэй байх эрхийн баталгааг хангах нь” нийтлэл, УБ хот, 7 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=768> 2021.04.17-нд хандав.

<sup>53</sup> <http://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2018/05/2019-A12.pdf> 2021.04.04-ны өдөр хандав.

## 2.2. Хувь хүний нууц задарснаас үүсэх сөрөг үр дагавар

Дундговь аймагт өсвөр насны охины жирэмслэлттэй холбоотой мэдээлэл алдагдаж, нууцлал задарснаас болж охин амиа хорлож нас барсан тохиолдол гарсан харамсалтай үйл явдал тохиолдож байсан.<sup>54</sup> Эцэг, эх, багш, сургуулийн нийгмийн ажилтнууд хүүхдийн хувийн нууцыг алдагдуулснаас хүүхэд сэтгэл санааны хямралд орох, үе тэнгийнхэндээ доромжлуулж, ялгаварлан гадуурхагдах, үүнээс улбаалан өөр сургуульд шилжих, сургуулиас завсардах тохиолдлууд гардаг байна. Мөн сургуулийн дотуур байрны орчинд багш нь сурагчийнхаа нууцыг задруулснаас болж 2 хүүхэд амиа хорлосон харамсалтай тохиолдол ч гарсан гэдгийг судалгаануудад дурджээ. Ийнхүү сургууль, дотуур байр зэрэг хүүхдийн амьдрах, суралцах орчинд хувийн нууц мэдээлэл алдагдсанаар багш нар, сурагч нараар дамжин тардаг. Хэдийгээр Боловсролын тухай хууль, ХЭТХ-д хүүхдийн нууцлалыг хадгалах талаар болон нууцлалыг задруулсан тохиолдолд авах арга хэмжээг заасан боловч зөрчил гаргасан тохиолдолд арга хэмжээ авсан тохиолдол байдаггүй, энэ төрлийн зөрчил маш түгээмэл<sup>55</sup> гэж иргэний нийгмийн байгууллагууд дүгнэдэг. Сургуулийн эмч нар хүүхдийн эрүүл мэндтэй холбоотой нууцлалыг бусад хүүхдийн дэргэд хоорондоо ярилцах, цаашилбал, багш, нийгмийн ажилтан зэрэг сургуулийн бусад ажилтнуудад задруулдаг. Мөн дотуур байранд амьдардаг хүүхдүүд аливаа зөрчлийг багш, ажилтнуудад хэлэхийг хүсдэггүй, учир нь тэд нууцыг хадгалдаггүйгээс хүүхдүүд улам хүнд байдалд орохоос айдаг. Харин сурагч, эцэг эхчүүд хуулийн талаарх мэдлэггүйгээс гомдол мэдүүлдэггүй, хүүхдээ өөр сургуульд шилжүүлэхээс өөр арга хэмжээ авч чаддаггүй байна.<sup>56</sup>

Охидын дуу хоолой социологийн судалгаанд үзлэг хийсэн эмч болон хамт байсан хүнд сурагчдын хувийн нууцыг хадгалж чадна гэдэгт хэр итгэлтэй байна вэ гэсэн асуултад 52% нь сайн хэлж мэдэхгүй байна, баталгаагүй зүйл, 22% нь итгэхгүй байна, 19% нь тийм бүрэн итгэлтэй байна, 7% нь огт нууцалдаггүй гэж хариулсан буюу нийт судалгаанд хамрагдсан сурагчдын 10 хүүхэд тутмын 8 нь буюу 80.9% нь нууцлах эсэх нь баталгаагүй зүй хэмээн үздэг байна. Өөрөөр хэлбэл охидын үзлэгт орж буй охид анхнаасаа л үзлэгт орохдоо хувийн нууцыг хадгалах, хамгаалах, задруулахгүй байж чадна гэдэгт итгэдэггүй ч үзлэгт ордог байна.

Мөн судалгаанд охидын үзлэгийн дараа сэтгэл санаа хэрхэн өөрчлөгддөг вэ гэх асуултад 28% нь нэг их тавгүйтсэн юм байхгүй, 24% нь тэр үедээ үнэхээр таагүй байсан, заримдаа бодохоор хэцүү байдаг, 21% нь бусдын нууцлал алдагдсан байх вий гэсэн санаа зовинол их байдаг, 11% нь сэтгэл санаа маш тавгүйтдэг, дараа нь бодоход ч маш хэцүү санагддаг, 16% нь хэвийн байсан гэж тус тус хариулсан. Хамрагдсан охидын 56% нь үзлэг охидын сэтгэл санаанд тодорхой хэмжээнд дарамт болдог гэсэн хариултыг өгсөн.

УИХ-аас 2019 оны 62 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолд:

- 2/Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаар:

<sup>54</sup> НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаар Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагын сүлжээдээс НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд илгээх илтгэл, 2015 он, 15 дахь тал.

<sup>55</sup> Мөн тэнд.

<sup>56</sup> Мөн тэнд.

- д/сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа хүүхдийн эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалт, цахим орчны нөлөө, хүчирхийллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Зөрчлийн тухай, Эрүүгийн хууль тогтоомжийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр сурталчлах, хүүхдийн эрх, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалтай холбоотой өөрчлөлтийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлэх.

Хэдийгээр бодлогын төвшинд хүүхдийн нууцыг хамгаалах, ялгаварлан гадуурхалт, сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэхийг үүрэг болгосон шийдвэр, зөвлөмжүүд хангалттай гардаг. Гэхдээ хэрэгжүүлэх хадгалах, хамгаалах илүү нарийвчилсан процесс ажиллагааны зохицуулалтууд шаардлагатай, мөн хэрэгжилтэд хяналт тавихгүй нөхцөлд хэрэгжих боломжгүй юм. Энэ нь зөвхөн хэрэгжүүлэх төвшин ажиллаж байгаа мэргэжилтнүүдээс шалтгаалж байгаа гэж дүгнэх боломжгүй, нэг талаасаа хэрэгжүүлж буй мэргэжилтнүүдэд хангалттай мэдээлэл түгээж, хүний эрх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, мэдрэмжтэй үйлчилгээ үзүүлэх чиглэлд анхаарах, нөгөө талаасаа бодлого тодорхойлогч нар өөрсдөө хүний эрхийн мэдрэмжтэй бодлого гаргахад шаардлагатай.

Бодлогын баримт бичиг, дүрэм, журмуудад хүүхдийн эрхийг хангах, хамгаалах, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох талаар дурдсан байдаг ч, урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмол зохиох, үзлэгт оруулах гэж тусгадаг. Үүнийг анхан шатны нэгж дээр хэрэгжүүлэхэд удирдамж, чиглэл, зохицуулалт дутуу учир хүүхдийн эрхийг зөрчиж хэрэгжүүлдэг нөхцөл байдал харагддаг.

### 2.3. Хувь хүний нууц задалсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар бүлгийн 13.10-т “Хувь хүний нууцад халдах” гээд Хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хууль бусаар олж авсан, бусдад дамжуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ хэмээн зохицуулж өгсөн. Энэхүү гэмт хэргийг харилцаа холбоо, цахим хэрэгсэл ашиглаж, эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж үйлдсэн бол хүндрүүлэхээр зохицуулж өгсөн байна.

Харин Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлгийн 13.11-т “Хувь хүний нууцыг задруулах” буюу хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан бол хүндрүүлэхээр тусгаж өгсөн.

Эрүүгийн хуулийн 13.11 дэх зохицуулалтаас үзэхэд “охидын үзлэг” хийсэн эмч, холбогдох албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн эмч, эмнэлгийн байгууллагын албан хаагчид хүүхдийн эрүүл мэнд, гэр бүлийн харилцааны нууцыг задруулсан нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээхээр зохицуулалт тусгагдсан байна.

УИХ-д өргөн баригдсан “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль”-ийг дагалдан Зөрчлийн тухай хуулийн 6.27 дахь хэсэгт хэрэв тухайн хуулийг зөрчвөл зөрчлийн хариуцлага хүлээлгэхээр төсөл боловсруулагдсан байна.<sup>57</sup>

## 2.4. Бүлгийн дүгнэлт

Хувь хүний нууцын тухай хуулиар захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүл, хуулиар тогтоосон бусад нууцыг хамгаалахаар тусгагдсан. Хувь хүний нууцын тухай хууль 1995 онд батлагдсан, маш товч, хамрах цар хүрээ хангалттай хэмжээнд биш, мөн зохицуулалт нь хэт ерөнхий зэргээс шалтгаалж “охидын үзлэг” орсон, түүнтэй холбоотой нууцад хамаарах эсэх нь эргэлзээтэй. Нийгмийн шинээр үүсэж буй харилцааг шийдвэрлэхээр ХЗДХЯ-наас шинээр Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийг боловсруулан УИХ-д өргөн барьсан. УИХ-д өргөн барьсан хуулийн төсөлд хувийн мэдээлэл, нууцыг хадгалах, хамгаалах процесс, мөн хамгаалагдах хувийн мэдээллийг илүү өргөн хүрээтэй болгож өгсөн. Одоогийн төсөлд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан тухай мэдээлэл хамаарахаар тусгагдаж өгсөн зэрэг дэвшилттэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангид хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг олж мэдсэн хүн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр задруулсан, албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулах нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулж өгсөн. Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах зохицуулалтыг Боловсролын тухай хууль, ХХТХ зэрэг хуулиудад тусгаж өгсөн. Мөн ЭМС-ын тушаалуудаар батлагдсан журмуудад нууц хадгалах зарчмын зохицуулалтууд тусгагдсан. Гэхдээ хүүхдийн нууцыг хэрхэн хамгаалах, процессын зохицуулалт дутагдалтай, ингэснээр хүүхдийн нууцыг задруулсан нөхцөлд олж тогтоох, хариуцлага хүлээлгэхэд хүндрэлтэй.

Хэрвээ хүүхдийн хувийн нууц сургууль, дотуур байр зэрэг сурах, амьдрах орчинд задарсан, алдагдсан нөхцөлд ноцтой хор уршиг үүсгэх эрсдэлтэй. Хүүхдийн сурч боловсрох, амьдрах, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг суурь эрхүүд зөрчигдөх аюултай. Сургууль завсардах, сургууль шилжих, ялгаварлан гадуурхалтад өртөх, үл хайхрах, жигших, үл тоох, цаашлаад амиа хорлох хүртэл ноцтой үр дагавартай, нэмээд сэтгэл зүйн хор хохирлыг үлдээдэг.

Хүүхдийн нөхөн үржихийн эрүүл мэндийн мэдээлэл, бэлгийн амьдралын талаарх мэдээлэл, эрүүл мэндийн үзлэг, тусламж авсан эсэх мэдээлэл, үзлэгийн үр дүнгийн мэдээлэл зэргийг цогцоор хамгаалах, хувийн нууцыг хадгалах, хамгаалах, хэрэгжүүлэх процесс, арга замыг тодорхой ойлгомжтой болгох шаардлага зайлшгүй тавигдаж байна.

Өнөөгийн нөхцөлд хувийн нууц хамгаалах хүрээ хангалтгүй, нууц хадгалах, хамгаалах эсэх нь баталгаагүй нөхцөлд охидын үзлэгийг зохион байгуулах нь эрсдэлтэй, сөрөг үр дагавруудын дагуулж болзошгүй байна.

<sup>57</sup> <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/02/Huviin-Medeelel-Hamgaalah-Dagaj-garah.pdf> 2021.04.17-ны өдөр.

## Гурав. ОХИДЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

### 3.1. Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй бодлого, үйлчилгээ

ХХтХ-д гэр бүлийн орчинд, боловсролын орчинд, эрүүл мэндийн үйлчилгээ авахад, хэвлэл мэдээлэл, цахим орчинд, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээнд хүүхдийн эрхийг хамгаалах талаар тусгайлан зохицуулж өгсөн. Зөвхөн хуулиар зохицуулсан орчин, байгууллагуудаас гадна Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аль ч хувь хүн, хуулийн этгээд хүүхдийн эрхийг хамгаалах, хангах чиг үүрэгтэй юм.

НҮБ-ын хүүхдийн сангаас жендэрийн мэдрэмжгүй хүүхэд хамгааллын бодлого нь охид, хөвгүүд, өсвөр үеийнхний эмзэг байдлыг улам нэмэгдүүлнэ хэмээн үзэж охид хөвгүүд өсвөр үеийнхний онцлогт тохирсон олон талт, өөр өөр арга хэрэгсэл, мэдлэг ур чадвар, стратеги ашиглах ёстойг зөвлөдөг.

Хүүхэд бол хүчгүй, чадамжгүй хохирогчид, ямар ч идэвхгүйгээр ямар нэгэн үйлчилгээ тусламжийг хүлээн авагч биш. Харин охид эмэгтэйчүүд хүүхдүүд бол эрх эзэмшигч, идэвхтэй оролцогчид юм. Тиймээс хүүхдэд хамгааллын бодлого нь жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан байна гэдэг нь хүүхэд бие даасан байдал, өөрөө өөрийнхөө эзэн байх чадварыг хүндлэх замаар тэдний хамгаалалтын механизмыг сайжруулах, чадавхижуулах боломжийг олгоно гэдгийг ойлгох ёстой. Тиймээс шийдвэр гаргалтанд хүүхдүүдийн шууд оролцоог хангах, эрсдэл хүчин зүйлүүдийг тодорхойлж, эмзэг байдлыг бууруулах нь чухал<sup>58</sup> байна.

Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй хүүхэд хамгааллын бодлого бол үр дүн бус үйл явц юм. Энэ үйл явц нь:

- Жендэрээс үүдэлтэй өөр өөр эрсдэлт хүчин зүйлүүдийг тодорхойлох,
- Хүүхэд болоод насанд хүрэгчдийн ялгаатай эрх мэдэл, хүчийг ухамсарлан, охид эмэгтэйчүүд, хүүхэд төвтэй үйлчилгээг эрхэмлэх
- Охид хөвгүүд нь ижил нөхцөл байдалд хүйсээс шалтгаалан өөр өөр эрсдэлт хүчин зүйлүүдтэй тулгарах боломжтойг ойлгох зэргээс эхэлнэ.

#### а) Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй боловсрол орчин дахь хүүхэд хамгааллын бодлого

ХХтХ-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, мөрдөж ажиллахаар зохицуулж өгсөн. Хэрвээ эрсдэлд нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд сургалтын байгууллага, багш, албан тушаалтан, ажилтан ХХтХ-иар үүрэг хүлээсэн оролцогч талуудад мэдээлэх үүрэгтэй. Сургалтын байгууллага суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие махбодын шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл

<sup>58</sup> Promoting gender equality through UNICEF-Supported Programming in Child Protection; Operational Guidance [https://www.unicef.org/gender/files/Protection\\_Layout\\_Web.pdf](https://www.unicef.org/gender/files/Protection_Layout_Web.pdf)

хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд “сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга эзэмших”, “сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх”, “сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын хоорондын нөхөрсөг бус харилцаа, маргаан, зөрчлийг эвлэрүүлэх, зохицуулах, гэр бүлд нь мэдэгдэх зэргээр урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах”, “хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулж болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээнд хүүхдийг оролцуулахгүй байх”, “хүүхдийг согтуурах, мансуурах, донтох байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах” зэрэг чиг үүрэгтэй.

### **б) Жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй эрүүл мэндийн үйлчилгээ**

ХХтХ-ийн 7 дугаар бүлэгт эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүүхдийн эрхийг хамгаалах талаар зохицуулж өгсөн. Хэдийгээр хуулийн зохицуулалт тодорхой, товч, ерөнхий тусгагдсан ч эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ үзүүлэх холбогдох дүрэм журам, зааварчилгаанд жендэрийн болон хүүхдийн эрхийн мэдрэмжтэй хандах, зохицуулалтыг шинэчлэх, хүүхдэд ээлтэй эрүүл мэндийн үйлчилгээний орчин бий болгох шаардлагатай.

Гэтэл “охидын үзлэг” зохион байгуулах журмуудад охидод үзлэг хийх эмчийн хүйсийн талаар огт тусгаж өгөөгүй, хэрвээ эсрэг хүйсийн эмч үзлэг хийх бол охидоос ямар тодорхой зөвшөөрөл авах, охид үзлэгт орохыг зөвшөөрсөн ч, эсрэг хүйсийн эмчээр үзлэг хийлгэхийг хүсэхгүй нөхцөл ямар арга хэмжээ авах талаар тусгаж өгөөгүй. Энэ мэт практикт хамгийн их тулгарч буй асуудлууд нь бодлого тодорхойлогч, хэрэгжүүлэгчдээс хүний эрх, жендэрийн боловсрол, мэдрэмж, хандлагыг шаардаж байна.

## **3.2. Захиргааны журмаар охидын эрхийг хамгаалах**

Хэрвээ хүүхдийн эрхийн зөрчил үүссэн нөхцөлд ХЭТХ-ийн 7.4-т заасны дагуу үндэсний болон олон улсын холбогдох байгууллагад гомдол гаргах, шийдвэрлүүлэх эрхтэй байна. Хүний эрхийн комиссын тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд заасны дагуу захиргааны байгууллагууд буюу хуулиар тусгайлан зохицуулсан хүний эрхийг хамгаалах механизмын дагуу арга хэмжээ авах боломж байдаг.

### **а) Хүний Эрхийн Үндэсний Комисс**

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т заасны дагуу ХЭҮК нь Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой аливаа асуудлаар санал, зөвлөмж гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдэд хүргүүлэх эрхтэй байдаг.

Комиссын гишүүн хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаарх гомдол мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсхүл иргэн, байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээдийн хүсэлтээр шалгалт хийх, мэдээллийн хяналт шалгалт хийх эрхтэй байдаг.

Хэрвээ хүний эрх зөрчигдсөн гэж үзвэл хуулийн 20 дугаар зүйлд заасан процессын дагуу гомдол, мэдээлэл гаргах эрхтэй. Гомдол, мэдээллийг шалгаад үндэслэлтэй нөхцөл зөвлөмж холбогдох байгууллага, хувь хүн, албан тушаалтанд хүргэх бөгөөд хэрвээ зөвлөмжийг биелүүлээгүй нөхцөлд албан тушаалтны албан тушаалаас нь огцруулах, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг нь зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтад гаргах, Комиссын гишүүний зөвлөмжийн дагуу арга хэмжээ аваагүй нь албан тушаалтныг албан тушаалаас нь бууруулах, биелүүлэх хүртэлх хугацаанд хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, үйл ажиллагааг нь түр зогсоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах зэрэг арга хэмжээ авч мөн болно. Шаардлагатай нөхцөлд шаардлага, зөвлөмж, хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр, олон нийтэд мэдээлж болдог.

### **б) Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (Хүүхдийн эрхийн тухай хуулиар эрх олгосон)**

ХЭТХ-ийн Гэр, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хуулиар заасан чиг үүргээ хэрэгжүүлэх замаар хяналт тавих зэрэг тодорхой эрхийг олгосон.

Хуулиар хүлээсэн чиг үүрэг, оролцооны хэлбэрээр охидын эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх, шаардлагатай нөхцөлд арга зүйн дэмжлэг үзүүлэх аргуудаар охидын эрхийн зөрчлийг таслан зогсоох боломжтой байна.

### **3.3. Нийтийн эрх ашгийг хамгаалах шүүхийн нэхэмжлэл (Захиргааны хэргийн шүүх)**

Захиргааны журмаар явсан ч үр дүн гараагүй нөхцөлд Захиргааны хэргийн шүүхэд хандаж хүүхдийн эрхийн зөрчлийг таслан зогсооход чиглэсэн нэхэмжлэлийг гаргаж болно. Хүүхдийн эрхийн тухай хуулийн 19.1-т хүүхэд эрхээ зөрчигдсөн гэж үзвэл өөрөө болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч бусад иргэн, байгууллагаар уламжлан эрхээ хамгаалуулахаар хуульд тогтоомжид заасан журмын дагуу гомдол, нэхэмжлэл гаргах талаар дурдсан.

Хэрвээ тухайлсан хүүхэд болон хууль ёсны төлөөлөгч нь эрх нь зөрчигдсөн гэж үзвэл аль ч шүүхэд хандах эрх нээлттэй. Харин Захиргааны хэргийн шүүхэд ЗХШХШТХ-ийн 18.3-т заасны дагуу хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн эрх ашиг сонирхлыг төлөөлж эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүд мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй “нэхэмжлэлийн шаардлага нь тухайн байгууллагын дүрмийн зорилгод нийцсэн байх”, “дүрмийн зорилгын дагуу сүүлийн гурваас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх” гэж зохицуулж өгсөн байдаг.

Иймд хэрвээ хүүхдийн нийтлэг эрх ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл хуулиар тавьсан шаардлагыг хангаж буй хуулийн этгээд нь захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах захиргааны байгууллага албан тушаалтны акт, хэм хэмжээний акт, гэрээ, үйлдэл, үйл ажиллагаа нь хүүхдийн эрхийн зөрчил үйлдсэн гэдгийг тогтоолгох, эс үйлдэхгүйг хууль бус болохыг тогтоолгох, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийг даалгах зэрэг нэхэмжлэлүүдийг гаргах бүрэн боломжтой байдаг.

### 3.4. Бүлгийн дүгнэлт

Хүүхдийн эрх боловсрол сургалт, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд, цаашлаад бүхий л орчин хамгаалах үүргийг хүлээдэг. Жендэрийн болон хүүхэд хамгааллын бодлого нь хүүхдийн эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, мэдээлэх, хамгаалах цогц бодлого байхаар хуульд тусгагдсан байна. Хэрвээ хүүхдийн эрх зөрчигдсөн нөхцөлд үндэсний болон олон улсын эрх зүйн механизмаар хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, зөрчлийг арилгах нээлттэй. Хуулиар тусгайлан хүний эрхийг хамгаалах, хүүхдийн асуудал хариуцах чиг үүрэг бүхий захиргааны байгууллагуудад зөрчиж буй үйл ажиллагааг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах, зөвлөмж, шаардлага хүргүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх зэрэг эрхийг олгосон.

Захиргааны журмаар хүүхдийн эрхийг хамгаалах ажиллагаа амжилттай болоогүй, эсхүл хугацаа алдаж, шийдвэрлэгдэхгүй байгаа нөхцөл Захиргааны хэргийн шүүхэд хандаж нийтийн эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх боломжтой. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т хүүхдийн эрхийг хамгаалах, нийтийн мэндийг хамгаалахад чиглэсэн нэхэмжлэлийг ашгийн төлөө бус зорилготой, тодорхой шалгуур хангасан, нэхэмжлэл гаргаж буй чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага нэхэмжлэл гаргаж эрхийг нээж өгсөн.

Энэ хүрээнд шүүхийн журмаар нийтийн эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл гаргаж захиргааны байгууллагын хууль бус үйлдэл, эс үйлдэхгүйг хүчингүй болгох, тодорхой үйл ажиллагааг хийхийг даалгах зэрэг нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэх боломжтой.



## Дөрөв. БОДЛОГЫН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Д/д	ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ	ЗӨВЛӨМЖ БОЛГОХ ШИЙДЭЛ	ГОЛ ҮР ДҮН
1	ЭМС-ын 2017 оны А/399, 2020 оны А/364 тушаалуудын хавсралтаар батлагдсан журмууд нь ЗЕХ-ийн тусгайлан эрх олгосон байх, ХЗДХЯ-д бүртгэгдсэн байх зэрэг шаардлагуудыг хангаж байгаа эсэх	<ul style="list-style-type: none"> <li>· ЭМС-д хандаж тушаалуудын хууль зүйн үндэслэлийг нарийвчлан шалгах, хэрвээ хуулиар тусгайлан эрх олгоогүй нөхцөл өөрөө хүчингүй болгох, хэрвээ хуулиар тусгайлан эрх олгосон бол ЗЕХ-д заасан журмын дагуу хэм хэмжээний актын дахин боловсруулж нөлөөллийн шинжилгээ, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдүүдээр санал авах ажиллагаа зэргийг зохих журмын дагуу хийж ХЗДХЯ-ны хэм хэмжээний актын жагсаалтад бүртгүүлэхийг шаардах</li> <li>· Өсвөр үеийнхэнд чиглэсэн эрүүл мэндийн “Урьдчилан сэргийлэх” үзлэгийн талаарх Эрүүл мэндийн сайдын баталсан дараах эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд дагаж мөрдөхөд хяналт тавих, эрчимжүүлэх,</li> <li>· ХЗДХЯ-д хандаж ЭМС-ын 2017 оны А/399, 2020 оны А/364 тушаалуудын хавсралтаар батлагдсан журмуудын хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг албан ёсоор тодруулах, хэрвээ бүртгэлгүй гэсэн хариу ирвэл холбогдох хууль зүйн арга хэмжээг авах</li> </ul>	Хуулиар тусгайлан эрх олгоогүй байхад “охидын үзлэг” зохион байгуулах журам баталсан ЭМС-ын тушаалууд хүчингүй болно. Цаашид дахин журам гаргахдаа ЗЕХ-д заасан шаардлагыг хангасан, хуулиар тогтоосон журам, зохих судалгааны үндсэн дээр хүний эрхэд суурилсан хандлагад үндэслэн боловсруулах боломжтой.
2	Сургуулийн орчинд “охидын үзлэг” хийхийг таслан зогсоох	<ul style="list-style-type: none"> <li>· БШУЯ-наас 2015 оноос хойш үзлэг хийгээгүй хэмээх байр суурьтай байгаа хэдий ч бодит тохиолдол, “Охидын дуу хоолой-2019” социологийн судалгаагаар батлагдаж байгаа тул хуулиар боловсролын салбарын бодлогыг тодорхойлох чиг үүргээ хэрэгжүүлэх, сургуулийн орчинд “охидын үзлэг” хийхийг таслан зогсоох арга хэмжээ авахыг шаардах</li> <li>· Эрүүл мэндийн хичээлийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн агуулгыг хүртээмжтэй, чанартай олгох, мэргэжлийн багшаар хичээл заалгах,</li> <li>· Эрүүл мэндийн сайн дурын зөвлөгөө, шинжилгээ, урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдлыг таниулж, сурталчлах арга хэмжээг шат дараатай зохион байгуулах,</li> <li>· Анги, бүлгээр нийтэд нь эрүүл мэндийн үзлэгт хамруулахыг зогсоож, өсвөр үеийнхнийг сайн дурын үндсэн дээр тогтмол эрүүл мэндийн зөвлөгөө, шинжилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлэх</li> </ul>	“Охидын үзлэг”-ийг сургуулийн орчинд зохион байгуулахгүй байх нь 1-рт зориулалтын бус орчинд хийгдэхээ болих, 2-рт хувийн нууц задрах зэрэг бусад сөрөг үр дагавруудыг багасна.

3	Захиргааны журмаар “охидын үзлэгийг” сургуулийн орчинд зохион байгуулахыг таслан зогсоох	<ul style="list-style-type: none"> <li>ХЭҮК болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд нь хуулиар хүүхдийн эрхийн зөрчил гарсан нөхцөл байдалтай холбоотой шалгалт хийх, зөрчлийг арилгуулах, арга зүйн зөвлөмж өгөх зэрэг эрх хэмжээ олгогдсон. Эдгээр байгууллагуудад мэдэгдэж охидын эрхийг зөрчлийг арилгуулах</li> </ul>	Хуулиар эрх хэмжээ олгогдсон байгууллагууд хуулийн хүрээнд шаардлага хүргүүлснээр үр дүнтэй болох магадлал өндөр, мөн богино хугацаанд үр дүн гарах боломжтой.
4	Захиргааны журмаар шийдвэрлэж чадаагүй нөхцөлд нийтийн эрх ашгийг төлөөлж нэхэмжлэл гаргах	<ul style="list-style-type: none"> <li>ЭМЯ болон БШУЯ-наас одоогийн баримталж буй бодлогоо эргэж хараагүй, төрийн эрх бүхий байгууллагуудаас захиргааны журмаар шийдвэрлэх оролдлого хийгээгүй, эсхүл шаардлага, зөвлөмжийг хүлээн аваагүй нөхцөлд ЗХШ-д хандаж нийтийн эрх ашгийг хамгаалах нэхэмжлэл гаргаж, шийдвэрлүүлэх</li> </ul>	ЭМЯ, БШУЯ-дын үйлдлийг хууль зөрчсөн гэдгийг тогтоолгох, мөн эс үйлдэхгүйг хууль бусад тооцуулах, тодорхой үйлдэл хийхийг даалгах боломжтой
5	Цагдаа, прокурорын байгууллагаас дахин “хүчирхийллийг илрүүлэх” зорилгоор охидын үзлэгийг зохион байгуулах шаардлага хүргүүлэхгүй байх	<ul style="list-style-type: none"> <li>Цагдаа, Прокурорын байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх үйл ажиллагаа нэрээр сургуулийн орчинд “охидын үзлэг”-ийг зохион байгуулахгүй байх, зохион байгуулахыг шаардахгүй байхыг удирдах дээд байгууллагуудад хүргүүлэх, нөхцөл байдлыг ойлгуулах</li> <li>Цагдаа, прокурорын байгууллагаас хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллийн мэдээллийг цуглуулах, илрүүлэх, хариу арга хэмжээ авах зорилгоор “урьдчилан сэргийлэх” үзлэгийн үр дүн, мэдээллийг албан бичгээр шаардах үйл ажиллагаа зохион байгуулахгүй байх.</li> </ul>	Сургуулийн орчинд “охидын үзлэг”-ийг хүчээр хийх эрсдэлийг бууруулна.
6	Эрүүл мэндийн үзлэгт орсон, үзлэгийн үр дүн нь зэрэг мэдээллүүд өнөөгийн эрх зүйн орчинд хамгаалагдах эсэх, хэрхэн хамгаалах нь хангалттай тодорхой биш байгаа	<ul style="list-style-type: none"> <li>“Охидын үзлэг”-т сайн дураар орж байгаа нөхцөлд үзлэгт орсон, үзлэгийн үр дүнг нууцалдаг байх, үзлэг хийсэн болон хамт байсан мэргэжилтнүүд нууцын баталгаа гаргаж, нууцыг задруулсан, алдсан нөхцөлд эрүүгийн болон зохих хариуцлагыг хүлээдэг тогтолцоог бүрдүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулах, шийдвэр гаргах төвшинд хүргэх</li> <li>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлийг мөрдлөг болгон, хэрэгжүүлэн ажиллах,</li> <li>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцах</li> </ul>	Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах бодит тогтолцоо бий болох

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц
4. Иргэний хууль
5. Захиргааны Ерөнхий хууль
6. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
7. Хүүхдийн эрхийн тухай хууль
8. Хүүхэд хамгааллын тухай хууль
9. Хувь хүний нууцын тухай хууль
10. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль
11. Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хууль
12. Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хууль
13. Шүүх шинжилгээний тухай хууль
14. УИХ-аас 2019 оны 62 дугаар “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоол
15. Засгийн газрын 2017 оны 78 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр
16. Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны А/399 дугаар тушаал, түүний хавсралт
17. Эрүүл Мэндийн Сайдын 2020 оны А/364 дугаар тушаал, түүний хавсралт
18. ХЭҮК-оос 2019 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 01/30 дугаар ЭМС-д хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан.
19. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн үзэл баримтлал <https://mojha.gov.mn/wpcontent/uploads/2021/02/%D2%AE%D0%B7%D1%8D%D0%B-%D0%B1%D0%B0%D1%80%D0%B8%D0%BC%D1%82%D0%BB%D0%B0%D0%BB.pdf>

### НИЙТЛЭЛ, СУДАЛГАА, ЯРИЛЦЛАГА

1. О.Мөнхсайхан “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үндсэн эрхийн хүрээг тодорхойлох нь” Хүний эрх сэтгүүд, 2016/01
2. О.Мөнхсайхан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар халдашгүй, чөлөөтэй байх эрхийн баталгааг хангах нь” нийтлэл, УБ хот, 7 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=768>
3. Ц.Цогт “Үндсэн хуулийн “...төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм...-ийн баталгааг бүрдүүлэх” зохицуулалтын товч тайлбар
4. НҮБ-ын БШУСБ, ТХЗ, “Бэлгийн боловсрол олон улсын арга зүйн удирдамж” нотолгоонд суурилсан аргачлал, УБ 2019 он, 19 дэх тал.
5. Японы хүүхдийг ивээх сангийн дэмжлэгтэйгээр, Гүнж төв, “Охидын дуу хоолой” Ерөнхий Боловсруулсан Сургуулиуд дээр хийгддэг охидын үзлэгийн талаарх судалгааны тайлан, УБ, 2020 он
6. НҮБ-ын хүүхдийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын тавдугаар тайлан илтгэлтэй холбогдуулан төрийн бус байгууллагын сүлжээдээс НҮБ-ын хүүхдийн эрхийн хороонд илгээх илтгэл, 2015 он

7. ХЭҮК “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дэх илтгэл”
8. ХТҮГ, НҮБ-ын Хүүхдийн сан “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хамгаалагдах эрхийн нөхцөл байдал” судалгааны тайлан, УБ хот, 2014 он, 28 дахь тал.
9. Б.Оюунбилэг “Охидын үзлэгийг сэргээе” [www.unuudur.mn](http://www.unuudur.mn) вэб сайт, 2019.03.06-ны өдөр нийтлэгдсэн, <https://unuudur.mn/%D0%BE%D1%85%D0%B8%D0%B4%D1%8B%D0%BD%D2%AF%D0%B7%D0%BB%D1%8D%D0%B3%D0%B8%D0%B9%D0%B3%D1%81%D1%8D%D1%80%D0%B3%D1%8D%D1%8D%D0%B52/>
10. Гүнж төв ТББ-ын үүсгэн байгуулагч Ч.Ундрахын ярилцлага <https://www.urug.mn/news/5170>
11. <https://childrenandaids.org/sites/default/files/202002/International%20technical%20guidance%20on%20sexuality%20education%20an%20evidence-informed%20approach-%20Mongolian.pdf>
12. WHO, United Nations agencies call for ban on virginity testing [https://www.who.int/news/item/17-10-2018-united-nations-agencies-call-for-ban-on-virginity-testing?fbclid=IwAR2miik-D0gpjHA5FLpAGI\\_EoF2naCCJGyTLK-MIrunVfhMpTzXRrPJ3KPPQ](https://www.who.int/news/item/17-10-2018-united-nations-agencies-call-for-ban-on-virginity-testing?fbclid=IwAR2miik-D0gpjHA5FLpAGI_EoF2naCCJGyTLK-MIrunVfhMpTzXRrPJ3KPPQ)
13. Qin, J., Saraiya, M., Martinez, G., & Sawaya, G. F. (2020). Prevalence of potentially unnecessary bimanual pelvic examinations and Papanicolaou tests among adolescent girls and young women aged 15-20 years in the United States. *JAMA internal medicine*, 180(2), 274-280
14. Promoting gender equality through UNICEF-Supported Programming in Child Protection; Operational Guidance [https://www.unicef.org/gender/files/Protection\\_Layout\\_Web.pdf](https://www.unicef.org/gender/files/Protection_Layout_Web.pdf)

#### ОНЛАЙН ЭХ СУРВАЛЖ

1. <http://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2018/05/2019-A12.pdf>
2. <https://www.mydarkhan.mn/a/274>
3. <http://peak.mn/news/gunj-tuw-okhidiin-uzlegiig-zogsookhiig-shaardlaa>
4. <https://legaldata.mn>
5. [https://www.unicef.org/gender/files/Protection\\_Layout\\_Web.pdf](https://www.unicef.org/gender/files/Protection_Layout_Web.pdf)
6. <https://www.urug.mn/news/5170>
7. [www.unuudur.mn](http://www.unuudur.mn)
8. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## ХАВСРАЛТ-1. ЭМСайд С.Энхболдод хүргүүлсэн албан бичиг

## Хөөрхөн Зүрхнүүдийн Аян, ТББ



Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооё!



/bitfulhearts

976+70159688

huurhunzurh@gmail.com

Огноо: 2021.03.02

№21/11

Улаанбаатар хот

## ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД С.ЭНХБОЛД ТАНАА

Хүсэлт илгээх нь

"Хөөрхөн Зүрхнүүдийн Аян" ТББ /цаашид "Хөөрхөн Зүрх" ТББ гэх/ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө 2012 оноос эхлэн ажиллаж буй төрийн бус, шашин болон нам, ашгийн бус байгууллага юм. Бидний алсын хараа эрүүл аюулгүй нийгмийн төлөө бодлогод нөлөөлөх, олон нийтийг хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлах хангах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагад нөлөө үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухуулан сурталчлах ажиллагааг эерэг аргаар нийгмийн хандлагыг өөрчлөх зорилго дор салбар бүрийн залуусын нэгдэл билээ.

"Монфемнет" Үндэсний сүлжээ байгууллага, "Хөөрхөн Зүрх" ТББ, "ГҮНЖ" Төв, "Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд" ТББ-ууд хамтран зарим орон нутгийн Ерөнхий Боловсролын Сургууль дээр нийтгээр нь албадан, охидын болон эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр бие махбодын, бэлгийн халдашгүй дархан байдалд халдан эрүүл мэндийн охидын үзлэг явуулдаг байж болзошгүй мэдээллийн дагуу 2019 оны 10-р сарын 30-ны өдрийн 03/19 тоот албан бичгээр Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс-г хандаж байсан.

Тус албан бичгийн хариуд Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Эрүүл Мэндийн Яамруу 2019 оны 06-р сарын 04-ны өдөр 01/30 тоот зөвлөмжийг илгээсэн. Үүнд:

1. Эмч эмнэлгийн байгууллагын ажилтнуудад бага насны хүүхэд болон өсвөр насны хүүхдүүдтэй харилцах үйлчилгээний стандартыг хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцүүлэн боловсруулж, хяналт, хариуцлагын тогтолцоог өндөржүүлэх;
2. Эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнуудын мэргэшил, мэргэжлийн ёс зүй, зан харилцаа болон хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг тогтмолжуулан, сургалтын хөтөлбөр, түүний агуулга, үр нөлөөнд үнэлгээ хийн тогтмол сайжруулж байх;
3. Өсвөр насныхны үзлэг оношилгооны нууцлал, мэдээллийг чандлан хадгалах, баталгаа зохицуулалтыг журамлах; Ингэхдээ өсвөр насныхны эрүүл мэндийн үзлэгийн үр дүнг шаардлагатай бол тодорхой хугацаанд эцэг эхэд мэдэгдэхгүй тэр дундаа багшид мэдэгдэхгүй байхаар зохицуулах;
4. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны стандарт, шаардлагыг чанд мөрдүүлэх, ялангуяа стандарт, шаардлага хангаагүй нөхцөлд нууцаар үр хөндсөн үйлдлийг илрүүлж, холбогдох байгууллагад мэдээлж, хариуцлага тооцдог болох;
5. Үр зулбуулах эмийн худалдаа, хэрэглээний хяналтыг нэмэгдүүлж, эмч, эмнэлгийн ажилтан, эмийн сангаар хяналтгүйгээр үр зулбуулах эм зардаг байдлыг таслан зогсоох;
6. Боловсролын байгууллагатай нягт уялдаатай ажиллаж жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын боловсрол эзэмших үйл явц, сургуульд хамрагдалтад анхаарал хандуулж, боломжит хувилбараар ерөнхий боловсролыг завсардалтгүй олгох боломжийг бүрдүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 58-р байр Y4 тоот  
Утас: 70159688, 95959688 И-мэйл: [huurhunzurh@gmail.com](mailto:huurhunzurh@gmail.com) Вэб: [www.bitfulhearts.org](http://www.bitfulhearts.org)

# Хөөрхөн Зүрхнүүдийн Аян, ТББ



Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооё!



Instagram: /btifulhearts



976+70159688



huurhunzurh@gmail.com

7. Сургуулийн дотуур байр, айлд байдаг, асрамж халамжийн газарт байрладаг өсвөр насны хүүхэд болон айлд малладаг хүүхдүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарал хандуулах;
8. Өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эх барих эмч, мэргэжилтнүүдийн батлагдсан орон тоог бүрэн хангах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах;
9. Өсвөр насны охидын жирэмслэлт, ураг зулбалт, үр хөндүүлэлт, төрөлтийг нэг бүрчлэн бүртгэж, улсын, хувийн хэвшлийн, аймаг, нийслэлийн зэргээр төрөх эмнэлгүүдийн судалгаа гаргаж, нэгдсэн статистик мэдээлэлтэй байх;

Манай байгууллага 2021 онд "Охидын үзлэг хийх асуудлаар" бодлогын судалгааг охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоох зорилго бүхий "Нэг тэрбумаараа тэмцье" олон улсын нөлөөллийн аяны хүрээнд боловсруулахаар төлөвлөж байна.

Та бүхэн бидний ажилд туслалцаа үзүүлэн Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасны дагуу дээрх зөвлөмжийн мөрөөр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болон шийдвэрлэсэн байдал, зөвлөмжийн хариуг албан бичгийг бидэнд илгээж хамтран ажиллана гэдэгт илтгэлтэй байна.

**Жич:** Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын 2019 оны 6-р сарын 04-ны өдөр 01/30 тоот зөвлөмжийн хуулбарыг хавсаргав.

Хүндэтгэсэн



Б.Оюундарь, Ерөнхий зохицуулагч

ХАВСРАЛТ-2. ХЭҮК-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч,  
гишүүн Ж.Хунанд хүргүүлсэн албан бичиг

# Хөөрхөн Зүрхнүүдийн Аян, ТББ



Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооё!



YouTube /bitifulhearts



976+70159688



huurhunzurh@gmail.com

Огноо: 2021.03.02

№21/12

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, ГИШҮҮН Ж.ХУНАН ТАНАА**

Хүсэлт илгээх нь

"Хөөрхөн Зүрхнүүдийн Аян" ТББ /цаашид "Хөөрхөн Зүрх" ТББ гэх/ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө 2012 оноос эхлэн ажиллаж буй төрийн бус, шашин болон нам, ашгийн бус байгууллага юм. Бидний алсын хараа эрүүл аюулгүй нийгмийн төлөө бодлогод нөлөөлөх, олон нийтийг хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлах хангах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагад нөлөө үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухуулан сурталчлах ажиллагааг эерэг аргаар нийгмийн хандлагыг өөрчлөх зорилго дор салбар бүрийн залуусын нэгдэл билээ.

"Монфемнет" Үндэсний сүлжээ байгууллага, "Хөөрхөн Зүрх" ТББ, "ГҮНЖ" Төв, "Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд" ТББ-ууд хамтран зарим орон нутгийн Ерөнхий Боловсролын Сургууль дээр нийтээр нь албадан, охидын болон эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр бие махбодын, бэлгийн дархан халдашгүй байдалд халдан эрүүл мэндийн охидын үзлэг явуулах гэж буй мэдээллийн дагуу хандан холбогдох арга хэмжээ авч өгөх тухай 2019 оны 10-р сарын 30-ны өдрийн 03/19 тоот албан бичгийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс-т хүргүүлж байсан.

Бидний хүсэлтийн хариуд Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 01/30 тоот зөвлөмжийг 2019 оны 6-р сарын 4-ны өдөр Эрүүл Мэндийн Яамд илгээсэн байдаг.

Манай байгууллага нь "Нэг тэрбумаараа тэмцье" олон улсын нөлөөллийн аяныг Монгол Улсад 9 дэх жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд энэ жил "Бидний дуу хоолой" сэдвийн дор сургуулийн орчинд хийж буй охидын үзлэгийг халах, бодлогын баримт бичиг, журамд өөрчлөлт оруулах зорилготойгоор нэг сарын хугацаанд хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Тус зорилгын хүрээнд манай байгууллагаас "Охидын үзлэгийн асуудалд" бодлогын судалгааны ажил боловсруулж, эрх бүхий байгууллагад нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Эрүүл Мэндийн Яамд 2019 оны 6-р сарын 4-ны өдөр илгээсэн 01/30 тоот зөвлөмжийн дагуу Эрүүл мэндийн Яамнаас ирүүлсэн хариуг бидэнд илгээж туслахыг хүсч байна. Хүний эрхийг хамгаалах үйлсэд хамтран зүтгэж, дэмжлэг үзүүлж байдаг та бүхэнд баярлалаа.

Хүндэтгэсэн



Б.Оюундарь, Ерөнхий зохицуулагч

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 58-р байр Ү4 тоот  
Утас: 70159688, 95959688 И-мэйл: [huurhunzurh@gmail.com](mailto:huurhunzurh@gmail.com) Вэб: [www.bitifulhearts.org](http://www.bitifulhearts.org)

ХАВСРАЛТ-3. БШУСайд Л.Энх-Амгаланд хүргүүлсэн албан бичиг

# Хөөрхөн Зүрхнүүдийн Аян, ТББ



Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсооё!



/bfulhearts



976+70159688

huurhonzurh@gmail.com

Огноо: 2021.03.02

№21/13

Улаанбаатар хот

## БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Хүсэлт илгээх нь

"Хөөрхөн Зүрхнүүдийн Аян" ТББ /цаашид "Хөөрхөн Зүрх" ТББ гэх/ нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоохын төлөө 2012 оноос эхлэн ажиллаж буй төрийн бус, шашин болон нам, ашгийн бус байгууллага юм. Бидний алсын хараа эрүүл аюулгүй нийгмийн төлөө бодлогод нөлөөлөх, олон нийтийг хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлах хангах, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлж, хандлагад нөлөө үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ухуулан сурталчлах ажиллагааг эерэг аргаар нийгмийн хандлагыг өөрчлөх зорилго дор салбар бүрийн залуусын нэгдэл билээ.

"Монфемнет" Үндэсний сүлжээ байгууллага, "Хөөрхөн Зүрх" ТББ, "ГҮНЖ" Төв, "Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд" ТББ-ууд хамтран зарим орон нутгийн Ерөнхий Боловсролын Сургууль дээр нийтээр нь албадан, охидын болон эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр бие махбодын, бэлгийн дархан халдашгүй байдалд халдан эрүүл мэндийн охидын үзлэг явуулах гэж буй мэдээллийн дагуу хандан холбогдох арга хэмжээ авч өгөх тухай 2019 оны 10-р сарын 30-ны өдрийн 03/19 тоот албан бичгийг Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс-т хүргүүлж байсан.

Тус албан бичгийн хариуд Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос Эрүүл Мэндийн Яамд 2019 оны 6-р сарын 04-ны өдөр 01/30 тоот зөвлөмжийг хүргүүлж байсан. Үүнд:

- Боловсролын байгууллагатай нягт уялдаатай ажиллаж, жирэмсэн болон хүүхэд төрүүлсэн өсвөр насны охидын боловсрол эзэмших үйл явц, сургуульд хамрагдалтад анхаарал хандуулж, боломжит хувилбараар ерөнхий боловсролыг завсардалтгүй олгох боломжийг бүрдүүлэх;
- Өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, эх барих эмч, мэргэжилтнүүдийн батлагдсан орон тоог бүрэн хангах, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангах;
- Өсвөр насны охидын жирэмслэлт, ураг зулбалт, үр хөндүүлэлт, төрөлтийг нэг бүрчлэн бүртгэж, улсын, хувийн хэвшлийн, аймаг, нийслэлийн зэргээр төрөх эмнэлгүүдийн судалгаа гаргаж, нэгдсэн статистик мэдээлэлтэй байх;

Манай байгууллагаас 2021 онд "Охидын үзлэгийн асуудлаар" бодлогын судалгааг охид, эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг таслан зогсоох зорилго бүхий "Нэг тэрбумаараа тэмцье" олон улсын нөлөөллийн аяны хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын зөвлөмжийн дагуу Эрүүл Мэндийн Яамтай хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай хариуг илгээж, бидний ажилд дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.

**Жич:** Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын 2019 оны 6-р сарын 04-ны өдөр 01/30 тоот зөвлөмжийн хуулбарыг хавсаргав.

Хүндэтгэсэн

Б.Оюундарь, Ерөнхий зохицуулагч

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 58-р байр Ү4 тоот  
Утас: 70159688, 95959688

И-мэйл: [huurhonzurh@gmail.com](mailto:huurhonzurh@gmail.com)

Вэб: [www.bfulhearts.org](http://www.bfulhearts.org)




## ХАВСРАЛТ-4. БШУЯ-наас ирүүлсэн хариу албан бичиг

## БАГА, СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АГУУЛГА ТУССАН БАЙДАЛ

Боловсролын түвшин	Анги	Агуулга (Ай, суралцахуйн зорилт)
Бага боловсрол	IV	ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 4,05.в. Өөрийн хувийн орон зайг мэдэх, хянах чадвартай болох
	V	ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 5,05.а. Гэр бүл, найз нөхөд, үе тэнгийнхний эрүүл харилцаа холбоог тодорхойлох, хөгжүүлэх, хадгалах 5,05.в. Дээрэлхэлт (цахим болон цахим бус)—ийг тодорхойлох, тэдгээрт өртөхгүй байх, хариу арга хэмжээ авах үр дүнтэй арга замыг үзүүлэх
Суурь боловсрол	IX	ЭМ09. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 9,05.б. Бэлгийн амьдрал, нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбогдох өөрийн үнэт зүйл, түүний зан үйлд үзүүлэх нөлөөг тодорхойлж, үнэт зүйл, итгэл үнэмшил, хандлагын ялгаатай байдлыг хүндэтгэхийн ач холбогдлыг ухаарах 9,05.в. Интернет, нийгмийн сүлжээний зэрэг, сөрөг нөлөөг (бусдын анхааралд өртөх, бэлгийн мөлжлөг г.м.) жишээгээр тайлбарлах, интернет, гар утас, нийгмийн сүлжээг аюулгүй ашиглах төлөвлөгөө боловсруулж хэрэглэх
Бүрэн дунд боловсрол	X	ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 10,05.б. Бэлгийн зан үйлийн хэлбэрийн аль нь зөв, буруу болохыг хууль тогтоомж, хүний эрхэд суурилан тайлбарлах; харилцан зөвшилцсөн бэлгийн зан үйл нь хувь хүний сонголт болохыг ухаарах 10,05.в. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн олон арга хэлбэрийг харьцуулах (үр дүнтэй байдал, үзүүлэх нөлөө г.м.), тэдгээрийг хэрхэн хэрэглэх талаар ярилцах, бэлгэвч зөв хэрэглэхийг бодит болон зурагт үзүүлэн дээр үзүүлэх, тайлбарлах
	XI	ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 11,05.в. Хосууд хоорондын харилцаа эрүүл, зөв, илэн далангүй байснаар бэлгийн харилцаа нь аюулгүй, харилцан зөвшилцсөн байж чаддагийг тайлбарлах; хүсэл хэрэгцээ, бэлгийн харилцааны хил хязгаарыг оновчтой илэрхийлэх
	XII	ЭМ05. БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД 12,05.б. Эцэг, эхийн үүрэг хариуцлагыг тодорхойлж, сайн эцэг, эх байх тухай өөрсдийн үнэт зүйлс, итгэл үнэмшлийн талаар тунгаан бодож, хүүхэдтэй болоход бэлэн болох нөхцөлийг үнэлэх 12,05.в. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бэлгийн хариу үйлдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, (өвчин эмгэг, стресс, бэлгийн хүчирхийлэл, эм хэрэглэх, хорт зуршил, гэмтэл) үүсч болох асуудал бэрхшээлийг тодорхойлох, тусламж хүсэх 12,05.д. Бэлгийн амьдралтай холбоотой мэдлэг, үнэт зүйл, хандлага, чадвараа ашиглан ирээдүйн амьдралаа төлөвлөх

**ХАВСРАЛТ-5. ХЭҮК-оос ирүүлсэн хариу албан бичиг**



**МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ  
КОМИССЫН ТАМГЫН ГАЗАР**

15140 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр,  
Утас: 26 29 31, 26 65 06, Факс: (976-11) 32 02 84,  
И-мэйл: info@nhrcm.gov.mn, Вэбсайт: www.nhrcm.gov.mn


2021.03.10 № 6/294  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


ХӨӨРХӨН ЗҮРХНҮҮДИЙН  
АЯН ТББ-Д

Танай байгууллагаас 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 21/12 тоот бичгээр ирүүлсэн хүсэлттэй танилцлаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос Эрүүл мэндийн яаманд 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/30 дугаар зөвлөмжийг хүргүүлсний дагуу тус яамнаас ирүүлсэн хариуг хуулбарлан хүргүүлэв.

Хавсралт 5 хуудастай.



ДАРГА  Ч.АЛТАНГЭРЭЛ

**152100071**

**ХАВСРАЛТ-6. Дархан-Уул аймгийн “Амин Холбоо” Өрхийн эрүүл мэндийн төвийн “Од” цогцолбор сургуулийн захиргаанд хүргүүлж байсан албан бичиг**

